



БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДЭЭС ГАРГАСАН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ



ЭРДЭНЭТ ХОТ
2013 ОН

ГАРЧИГ

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2013 он

СИТХ-ын ээлжит III хуралдаан зарлан хуралдуулах тухай 2013.01.22 № 01.....	6
Ажлын хэсэг байгуулах тухай 2013.01.22 № 02.....	7-8
Сумын ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 2013.01.22 № 03	9-10
Монгол улсын Сайн малчин цолоор шагнуулах тухай 2013.01.11 № 04.....	11
СИТХ-ын ээлжит III хуралдааныг хугацааг хойшлуулах тухай 2013.01.11 № 05.....	12
Мөнгө зарцуулах тухай 2013.01.11 № 06.....	13-14
Шинээр баригдсан орон сууцны байруудад хаяг өгөх тухай 2013.01.15 № 07.....	15
Рашаант, Эрдэнэ, Их залуу багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 2013.01.15 № 08.....	16
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай 2013.01.15 № 09.....	17-18
Цалин тогтоох тухай 2013.01.21 №10.....	19
Аймгийн сайын малчнаар шалгаруулах тухай 2013.01.21 № 11.....	20
Аймгийн тэргүүний тариаланч хамт олноор шагнуулах тухай 2013.01.21 № 12.....	21
Аймгийн тэргүүний фермерээр шалгаруулах тухай 2013.01.21 №13.....	22
Аймгийн тэргүүний тариаланчаар шагнуулах тухай 2013.01.21 № 14.....	23
Мөнгө зарцуулах тухай 2013.01.22 № 15	24
Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай 2013.01.22 № 16.....	25
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай 2013.01.22 № 17.....	26-27
Зэст багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 2013.01.28 № 18.....	28
Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэсгүүд байгуулах тухай 2013.01.30 № 19.....	29
Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 2013.01.30 № 20.....	30
Говил багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай 2013.01.30 № 21.....	31
Хуралдааны зардал гаргах тухай	

2013.01.30 № 22.....	32
Шагнаж урамшуулах тухай	
2013.01.30 № 23.....	33
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.01.30 № 24.....	34-35
ИТХ-ын дотоод зохион байгуулалт, Хурлын дэргэдэх Хороодын ажиллах журмыг батлах тухай	
2013.02.18 № 25.....	36-42
Багт ажиллах хэсгийн ахлагчдын тоо, урамшууллыг шинэчлэн тогтоох тухай	
2013.02.18 № 26.....	43
Дэнж, Согоот багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.02.18 №27	44
Шинээр баригдсан орон сууцны байруудад хаяг өгөх тухай	
2013.02.18 №28.....	45
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.02.18 №29.....	46
Сумын Засаг даргын нөөц санг зарцуулах, хяналт тавих журмыг батлах тухай	
2013.02.18 №30.....	47
Багуудын Иргэдийн Нийтийн хурлын хуралдааны тов зарлах тухай	
2013.03.07 №31.....	48
Багуудын Иргэдийн Нийтийн хурлын хуралдааны тов зарлах тухай	
2013.03.07 №32.....	49
Ажлын төлөвлөгөө батлах тухай	
2013.03.07 №33.....	50
ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны дотоод журам батлах тухай	
2013.03.07 №34.....	51-58
Дипломат болон албаны гадаад паспорт гаргуулах тухай	
2013.03.07 №34/а.....	59
СИТХ-ын ээлжит IV хуралдаан зарлан хуралдуулах тухай	
2013.03.07 №35.....	60
Арга хэмжээ авах тухай	
2013.03.07 №36.....	61
СИТХ-ын ээлжит бус IV хуралдааны товыг хойшлуулах тухай	
2013.03.18 №37.....	62
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.03.20 №38.....	63-64
Зарим багуудын Иргэдийн нийтийн хурлын Хуралдааныг дахин хуралдуулах тов зарлаж тухай	
2013.04.02 №39.....	65-66
Шинээр баригдсан орон сууцны байруудад хаяг өгөх тухай	
2013.04.02 №40.....	67
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.04.08 №41.....	68-70
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.04.08 №42.....	71-76
Журам батлах тухай	
2013.04.08 №43.....	77-79
Ажлын хэсэг томилох тухай	
2013.04.08 №44.....	80

Шагнуулах тухай	
2013.04.08 №45.....	81
Журам батлах тухай	
2013.04.15 №46.....	82
Шинээр баригдсан орон сууцанд хаяг өгөх тухай	
2013.04.15 №47.....	83
Шинээр баригдсан орон сууцанд хаяг өгөх тухай	
2013.04.29 №48.....	84
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.04.29 №49.....	85
Говил, Оюут, Согоот, Цагаанчулуут, Булаг багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.04.29 №50.....	86
Сумын ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.04.29 №51.....	87
Данс нээлгэх тухай	
2013.05.15 №52.....	88
Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэсгийн хорооны байрлалд өөрчлөлт оруулах тухай	
2013.05.15 №53.....	89
Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэсгийн хорооны байрлалд өөрчлөлт оруулах тухай	
2013.05.16 №54.....	90
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.05.24 №55.....	91-92
“Сумын 2013 оны төсөв батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай	
2013.05.29 №56.....	93
Уурхайчин, Эрдэнэ багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.05.29 №57.....	94
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.06.04 №58.....	95-96
Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	
2013.06.04 №59.....	97
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.06.12 №60.....	98-99
СИТХ-ын ээлжит V хуралдаан зарлан хуралдуулах тухай	
2013.06.12 №61.....	100
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.06.20 №62.....	101-102
Үндэсний баяр наадмын төсөв батлах тухай	
2013.07.03 №63.....	103
СИТХ-ын ээлжит V хуралдааны товыг хойшлуулах тухай	
2013.07.03 №64.....	104
Багийн ИНХ хуралдуулах тов тогтоох тухай	
2013.07.08 №65.....	105
Хүндэт тэмдэгээр шагнах тухай	
2013.07.08 №66.....	106-108
Багийн ИНХ хуралдуулах тов тогтоох тухай	

2013.07.17 №67.....	109
Шинээр баригдсан орон сууцны байруудад хаяг өгөх тухай	
2013.07.17 №68.....	110
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.07.17 №69.....	111-120
Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	
2013.07.17 №71/a.....	121-124
Баг хуваах тухай	
2013.07.17 №71.....	125
Булаг, Дэнж багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.08.22 №72.....	126
Бүрэнбүст, Уртбулаг багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.08.22 №73.....	127
Хүрэнбулаг, Зэст багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.08.22 №74.....	128
Их залуу, Цагаанчулуут багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.08.22 №75.....	129
Малчин, Шанд багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.08.22 №76.....	130
Согоот, Рашаант багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.08.22 №77.....	131
Сумын “Хүндэт тэмдэг”-ээр шагнах тухай	
2013.08.22 №78.....	132
Шинээр баригдсан орон сууцанд хаяг өгөх тухай	
2013.08.22 №79.....	133
Говил, Баянцагаан багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.09.17 №80.....	134
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.09.17 №81.....	135-137
СИТХ-ын ээлжит бус анхдугаар хуралдаан зарлан хуралдуулах тухай	
2013.09.24 №82.....	138
Засаг даргын үйл ажиллагаанд үнэлэлт өгөх тухай	
2013.10.03 №83.....	139
Багийн ИНХ хуралдуулах тов тогтоох тухай	
2013.10.10 №84.....	140-141
Сумын “Хүндэт тэмдэг”-ээр шагнах тухай	
2013.10.10 №85.....	142
Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.10.10 №86.....	143
Рашаант, Баянбулаг багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.10.10 №87.....	144
Иргэний танхим байгуулах, ажиллах журам батлах тухай	

2013.10.10 №88.....	145-151
СИТХ-ын ээлжит VI хуралдаан зарлан хуралдуулах тухай	
2013.10.24 №89.....	152
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.10.24 №90.....	153-155
Хүрэнбулаг, Их залуу багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.11.06 №91.....	156
Наран, Оюут багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.11.06 №92.....	157
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.11.06 №93.....	158-159
Сумын “Хүндэт тэмдэг”-ээр шагнах тухай	
2013.11.19 №94.....	160-161
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.11.19 №95.....	162-164
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.12.02 №96.....	165-179
Их залуу, Дэнж багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.12.02 №97.....	180
Хүрэнбулаг, Бүрэнбүст багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.12.02 №98.....	181
Зэст багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.12.02 №99.....	182
Сумын ИТХ-ын ээлжит VII хуралдаан зарлан хуралдуулах тухай	
2013.12.02 №100.....	183-184
Багуудын Иргэдийн нийтийн хуралдуулах тов тогтоох тухай	
2013.12.06 №101.....	185-186
Шинээр баригдсан орон сууцанд хаяг өгөх тухай	
2013.12.06 №102.....	187
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.12.13 №103.....	188-189
Сумын “Хүндэт тэмдэг”-ээр шагнах тухай	
2013.12.13 №104.....	190-192
Монгол Улсын Сайн малчин цолоор шагнуулах тухай	
2013.12.19 №105.....	193
Малчин, Эрдэнэ багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	
2013.12.19 №106.....	194
Монгол улсын Төрийн дээд шагнал одон, медалиар шагнуулах тухай	
2013.12.19 №107.....	195-196
Төсөв батлах тухай	
2013.12.27 №108.....	197



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 01

Эрдэнэт хот

**СИТХ-ын ээлжит III хуралдаан зарлан
хуралдуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. СИТХ-ын ээлжит III хуралдааныг 2013 оны 01 сарын 18-ны өдөр зарлан хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1. ИТХ-ын бүрэн эрхийн хугацаанд хийх ажлын үндсэн чиглэл батлах тухай
2. Сумын Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай
3. Сумын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай
4. Баян-Өндөр сумын 2013 оны газар зохион байгуулалтын тухай, 2013 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний тухай

Хоёр. Хуралдааны бэлтгэл ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтын ёсоор баталсугай.

Гурав. Хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг бэлтгэж 1 дүгээр сарын 14-нд Тэргүүлэгчдэд танилцуулахыг Засаг дарга /И.Баасанжав/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 02

Эрдэнэт хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

НЭГ. СИТХ-ын бүрэн эрхийн хугацаанд хийх ажлын үндсэн чиглэл, хороодын ажиллах журмыг боловсруулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

ХОЁР. Үндсэн чиглэл, хороодын ажиллах журмын талаарх саналаа Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхийг Ажлын хэсгийн дарга, Нарийн бичиг, гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн
02 дугаар тогтоолын хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	В.Баттулга
Нарийн бичгийн дарга	Я.Тунгалаг
Гишүүдэд:	Н.Жаргалсайхан
	Б.Ганбат
	П.Баянмөнх
	Л.Түмэндэмбэрэл
	М.Чулуунзагд
	Д.Ганболд
	Д.Цог-Очир
	Б.Батсайхан
	Н.Мэндбаяр
	Б.Хээрийнбаатар
	Д.Дашдорж

оОо



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 03

Эрдэнэт хот

**Сумын ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнд
Өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн дүн, ажил албаны ачааллыг харгалзан салбар зөвлөлийн дарга М.Толя, гишүүн З.Эрдэнээ, П.Мөнхзул нарыг чөлөөлж, даргаар Н.Жаргалсайхан, гишүүнээр Б.Батжаргал, Ч.Уламбаяр нарыг томилсугай.

2. Зөвлөлийн гишүүдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн нарийн бичиг С.Наранцэцэгт даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн
03 дугаар тогтоолын хавсралт

СУМЫН ГХУСАЗСЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог нэр	Гишүүнчлэл	Албан тушаал
1	Н.Жаргалсайхан	Дарга	ИТХ-ын дарга
2	С.Наранцэцэг	Нарийн бичгийн дарга	Сумын ЗДТГ-ын ХЗАХ ажилтан
3	Б.Батжаргал	Гишүүн	ХЭАХН-ийн тэргүүн
4	П.Өлзиймаа	Гишүүн	ЦГ-ын ОНХА-ны ахлах байцаагч
5	Н.Чулуунцэцэг	Гишүүн	ХТХ-ийн мэргэжилтэн
6	Б.Өлзийжаргал	Гишүүн	БСГ-ын мэргэжилтэн
7	Ж.Дорж	Гишүүн	ИГХХМН-ийн тэргүүн
8	Ц.Цэцэгмаа	Гишүүн	Сумын ЗДТГ-ын ХҮҮХ ажилтан
9	Ч.Уламбаяр	Гишүүн	АМЭА-ийн Орхон аймаг дахь салбарын захирал

оОо



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 04

Эрдэнэт хот

**Монгол улсын Сайн малчин цолоор
шагнуулах тухай**

Монгол улсын Засгийн газрын 2009 оны 70 дугаар тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Малчин багийн иргэн Сурмаагийн Магсарыг “Монгол улсын Сайн малчин” цолоор шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 05

Эрдэнэт хот

СИТХ-ын ээлжит III хуралдааныг
хугацааг хойшлуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 24.3 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын ИТХ-ын ээлжит III хуралдааны хугацааг хойшлуулж 01 сарын 31-ны өдөр хуралдуулахаар тогтоосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 06

Эрдэнэт хот

Мөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймаг, сумдын хамтын ажиллагааны хүрээнд туршлага солилцохоор ирсэн Булган аймгийн Баян-Агт сумын ИТХ-ын төлөөлөгчдөд өгөх бэлэг дурсгалын зардлыг хавсралтаар баталсугай.

2.Зардлын 126 /Нэг зуун хорин зургаан мянган/ төгрөгийг Төлбөр хураамж бусад зардлаас зарцуулахыг ня-бо /Г.Бүдхүү/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2013 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн
06 дугаар тогтоолын хавсралт

БУЛГАН АЙМГИЙН БАЯН-АГТ СУМЫН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ

ХҮЛЭЭН АВАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Бэлэг дурсгал	ш	15	8400	126 000
Дүн					126 000

оОо



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 07

Эрдэнэт хот

**Шинээр баригдсан орон сууцны байруудад
хаяг өгөх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Уурхайчин, Бүрэнбүст багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Уурхайчин багийн 3-6 дугаар байрны баруун талд баригдсан орон сууцыг 3-5 дугаар байр, Дэлгэрэх төвийн баруун талд баригдсан орон сууцыг 3-25 дугаар байр, Бүрэнбүст багийн 5-14 дүгээр байрны ард баригдсан Залуучуудын 50 айлын орон сууцыг дугаар байр гэж тус тус хаяглахаар тогтоосугай.

2. 3-5, 3-25, 5-16 дугаар байрны хаягжилт, иргэдийн хаягийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхийг Сумын Засаг дарга /И.Баасанжав/, Уурхайчин багийн Засаг дарга /Н.Давааням/, Бүрэнбүст багийн Засаг дарга /Ц.Энхтөр/ нарт даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 08

Эрдэнэт хот

**Рашаант, Эрдэнэ, Их залуу багийн Амьжиргааг дэмжих
зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт, Рашаант, Эрдэнэ, Их залуу багуудын ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Рашаант багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс О.Жаргалыг чөлөөлж, А.Баясгаланг томилсугай.

2. Эрдэнэ багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Р.Ганбат, З.Уранчимэг, С.Түмэндэлгэр нарыг чөлөөлж, Т.Алтанцэцэг, Ж.Адъяа, А.Уранбор нарыг томилсугай.

3.Их залуу багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Т.Цэцэгмандахыг чөлөөлж, Л.Отгонжаргалыг томилсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 09

Эрдэнэт хот

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай.

Үүнд:

Монгол улсын Хүний гавъяат эмч цолоор:

- | | | |
|---|----------------------|--|
| 1 | Сономын Зүмбэрэл | “Уран ачтан” эмнэлгийн зөвлөх эмч |
| 2 | Доржзовдын Баасанжав | БОЭТ-ийн Хүүхдийн тасгийн эрхлэгч, хүүхдийн зөвлөх эмч |

Алтан гадас одонгоор:

- | | | |
|---|---------------|---|
| 1 | Пүрэвийн Баяр | Эрдэнэт цогцолбор сургуулийн Технологийн багш |
|---|---------------|---|

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

1	Ядамсүрэнгийн Отгон	БОЭТ-ийн Сэтгэц наркологийн тасгийн эрхлэгч
2	Жанцангийн Оюундалай	БОЭТ-ийн Халдвартын эмч
3	Лхагважаргалын Ганболд	БОЭТ-ийн Эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч
4	Цэгмидийн Саранцэцэг	БОЭТ-ийн Халдвартын тасгийн эрхлэгч
5	Бямбаагийн Батбаяр	БОЭТ-ийн Мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний эмч
6	Нямандоржийн Цэцгээ	БОЭТ-ийн Дотор, зүрх судасны эмч
7	Цэрэндоржийн Сайнхүү	БОЭТ-ийн Салбар банкны бага эмч
8	Далайсономын Алимаа	БОЭТ-ийн Бариа заслын бага эмч
9	Гомбосүрэнгийн Энхтуяа	БОЭТ-ийн менежер
10	Адъяагийн Ариунаа	Баян-Өндөр цогцолбор сургуулийн Гадаад хэлний багш
11	Цэдэн-Ишийн Алтанцэцэг	Лаборатори VIII сургуулийн Математикийн багш
12	Лханаажавын Буянзаяа	Лаборатори VIII сургуулийн Бага ангийн багш
13	Түдэвийн Лхамсүрэн	Эрдэнэт цогцолбор сургуулийн Физикийн багш
14	Цэвээндоржийн Сэргэлэн	Эрдэнэт цогцолбор сургуулийн Хөгжмийн багш
15	Ванчиндоржийн Одсүрэн	Эрдэнэт цогцолбор сургуулийн Орос хэлний багш
16	Тогтохын Оюунаа	IV цэцэрлэгийн багш

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 10

Эрдэнэт

Цалин тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 239, 240 дүгээр тогтоол, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 38,6 дахь заалтуудыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажиллагсадын цалингийн санг 1 дүгээр хавсралтаар, Багийн Иргэдийн Нийтийн хурлын дарга нарын цалингийн санг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 11

Эрдэнэт

Аймгийн сайын малчнаар
шалгаруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйл, Орхон аймгийн Засаг даргын 2010 оны 185 дугаар захирамж, Малчин багийн ИНХ-ын тогтоол, багийн Засаг даргын саналыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Малчин багийн иргэн Сүрэнгийн Цэнд-Аюуш, Зунгаан Лувсаан, Сурмаагийн Магсар нарыг “Аймгийн сайн малчин”-аар шалгаруулахаар нэрийг дэвшүүлж, Аймгийн Засаг даргад уламжлахаар тогтоосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 12

Эрдэнэт

**Аймгийн тэргүүний тариаланч хамт
олноор шагнуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйл, Орхон аймгийн Засаг даргын 2010 оны 185 дугаар захирамж, Багийн ИНХ-ын тогтоол, багийн Засаг даргын саналыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Баян-Өндөр сумын “ХАНТАЙ БУЯН” ХХК-ийг “Аймгийн тэргүүний тариаланч хамт олон”-оор шалгаруулахаар нэрийг дэвшүүлж, Аймгийн Засаг даргад уламжлахаар тогтоосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 13

Эрдэнэт хот

**Аймгийн тэргүүний фермерээр
шалгаруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Орхон аймгийн Засаг даргын 2010 оны 185 дугаар захирамжийг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Баян-Өндөр сумын Малчин багийн иргэн Халтарын Эрдэнэбатыг “Аймгийн тэргүүний фермер”-ээр шалгаруулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг даргад уламжлахаар тогтоосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 14

Эрдэнэт

Аймгийн тэргүүний тариаланчаар
шагнуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйл, Орхон аймгийн Засаг даргын 2010 оны 185 дугаар захирамж, Багийн ИНХ-ын тогтоол, багийн Засаг даргын саналыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Баян-Өндөр сумын “Хантай баян” ХХК-ийн тариаланч Доржоогийн Хишигбатыг ногоочин Б.Эрдэнэчимэг нарыг “Аймгийн тэргүүний тариаланч”-аар шалгаруулахаар нэрийг дэвшүүлж, Аймгийн Засаг даргад уламжлахаар тогтоосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 15

Эрдэнэт

Мөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. ИТХ-ын хурлын хэрэгцээнд шаардлагатай байгаа хавсралтаар тооцсон 43750 /дөчин гурван мянга долоон зуун тавь/ төгрөгийг төлбөр хураамж, бусад зардлаас зарцуулахыг ня-бо Г.Бүдхүүд зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 16

Эрдэнэт хот

Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Монголын уламжлалт Цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан ИТХ-ын даргаар ажиллаж байсан Х.Буянхишиг, жолоочоор ажиллаж байсан С.Гиваасүрэн нарт хүндэтгэл үзүүлэхэд 60000 /Жаран мянган/ төгрөгийг зарцуулсугай.

2.Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 60000 /Жаран мянган/ төгрөг зарцуулахыг ня-бо Г.Бүдхүүд зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 17

Эрдэнэт хот

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай.

Үүнд:

Монгол улсын Гавъяат жүжигчин цолоор:

- | | | |
|---|---------------------|-----------|
| 1 | Намсрайн Цэцэгсүрэн | Тэтгэвэрт |
|---|---------------------|-----------|

Монгол улсын Хөдөлмөрийн баатар цолоор:

- | | | |
|---|-----------------------|-----------|
| 1 | Аюурзанын Лхагвасүрэн | Тэтгэвэрт |
|---|-----------------------|-----------|

Алтан гадас одонгоор:

- | | | |
|---|------------------------|-----------|
| 1 | Дамдинжавын Чимэдтогос | Тэтгэвэрт |
|---|------------------------|-----------|

2	Чойцилсүрэнгийн Должинсүрэн	Тэтгэвэрт
3	Намхарын Дашдорж	БОЭТ-ийн эмийн сангийн эрхлэгч
4	Пүрэвсүрэнгийн Ганболд	Тэтгэвэрт
5	Мягмарын Бямбасүрэн	Тэтгэвэрт
6	Цэвэлдоржийн Долгорсүрэн	Тэтгэвэрт
7	Жиндээгийн Цэвэлмаа	Тэтгэвэрт

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 18

Эрдэнэт хот

**Зэст багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт, Зэст багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Зэст багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Ж.Нарангэрэл, М.Ариунаа нарыг чөлөөлж, Б.Батлхагва, Б.Ганболд нарыг томилсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 19

Эрдэнэт хот

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн
хэсгүүд байгуулах тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь заалтуудыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хэсгүүдийн дугаар, нутаг дэвсгэр, төвийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 20

Эрдэнэт хот

**Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт, Зэст багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс О.Батцэнгэл, Х.Бат-Эрдэнэ, Д.Уранмандах нарыг чөлөөлж, Д.Тунгалаг, Г.Ганчимэг, Т.Ичирхорлоо нарыг томилсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 21

Эрдэнэт хот

**Говил багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт, Говил багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Говил багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Б.Баярцэцэг, С.Цогбадрах нарыг чөлөөлж, Я.Намжилсүрэн, Д.Сэр Од нарыг томилсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 22

Эрдэнэт хот

Хуралдааны зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 6 дахь удаагийн сонгуулийн ээлжит III хуралдааны өдрийн хоолны зардалд 170 000 /Нэг зуун далан мянган/ төгрөгийг зарцуулсугай.

2.Төлбөр хураамж бусад зардлаас 170 000 /Нэг зуун далан мянган/ төгрөгийг зарцуулахыг ня-бо Г.Бүдхүүд зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 23

Эрдэнэт хот

Шагнаж урамшуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Монголын багш нарын 47 дахь өдрийг тохиолдуулан Эрдэнэт цогцолбор сургуулийн бага ангийн багш Пүрэвжавын Туяа /ФБ71090306/, Орхон цогцолбор сургуулийн Орос хэлний багш Баасанжавын Бүдлхагва /ГЮ61092000/ нарыг ИТХ-ын баярын бичиг, 15000 /Арван таван мянган/ төгрөгөөр шагнахаар тогтоосугай.

2.Нэг удаагийн тэтгэмж урамшууллын сангаас 30000 /Гучин мянган/ төгрөг зарцуулахыг ня-бо Г.Бүдхүүд зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 24

Эрдэнэт хот

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалт, Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай.

Үүнд:

Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор:

- | | | |
|---|-------------------------|--|
| 1 | Данзангийн Цэдэндамбаа | Орхон аймгийн хуульчдын холбооны
Сонины менежер |
| 2 | Дорлигсүрэнгийн Батбаяр | “Ленда” ХХК-ийн захирал |

Монгол улсын Гавъяат эдийн засагч цолоор:

- | | | |
|---|-------------------------|--|
| 1 | Түмэнжаргалын Балжинням | Монголын эрдэс баялгийн салбарын
ахмадын нэгдсэн хорооны Гүйцэтгэх
захирал |
|---|-------------------------|--|

Монгол улсын Гавъяат жүжигчин цолоор:

- | | | |
|---|------------------|---|
| 1 | Дашмагваны Чимэд | Хүүхэд гэр бүлийн хэлтсийн Уртын дууны багш |
|---|------------------|---|

Алтан гадас одонгоор:

- | | | |
|---|--------------------|-----------|
| 1 | Дашийн Цэрэндэлгэр | Тэтгэвэрт |
| 2 | Жүгдэрийн Дамба | Тэтгэвэрт |

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

- | | | |
|---|----------------------------|-------------------------------|
| 1 | Дамбаренчингийн Мөнхбаатар | “Ораметалл” ХХК-ийн Засварчин |
|---|----------------------------|-------------------------------|

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 25

Эрдэнэт

ИТХ-ын дотоод зохион байгуулалт,
Хурлын дэргэдэх Хороодын ажиллах
журмыг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 20 дугаар зүйлийн 20.3, 18 дугаар зүйлийн 18.1.1 “в”, 21 дүгээр зүйлийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчийн хурлаас ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод зохион байгуулалтын бүтцийг нэгдүгээр хавсралтаар, “ИТХ-ын дэргэдэх хороодын ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэхүү журмын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын дарга Н.Жаргалсайхан, Тэргүүлэгчид, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч нарт даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2013 оны 02 дүгээр сарын 18-ны өдрийн
25 дугаар тогтоолын 1-р хавсралт

**БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**



oOo

Баян-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2013 оны 02 дүгээр сарын 18-ны өдрийн
25 дугаар тогтоолын 2-р хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, бусад хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал дүгнэлт гаргах, Хурлын тогтоол шийдвэрийн биелэлтийг хянан шалгах, Баян-Өндөр сумын хөгжил, багууд болон иргэдийн амьдралд тулгамдаж буй асуудлуудыг нарийвчлан судалж шийдвэрлэх, Хурлын тасралтгүй байнгын үйл ажиллагааг хангахад оршино.

Нэг. Хороо нь дараах байдлаар ажиллана.

1. Хороо нь хариуцсан чиглэлээр асуудлыг судалж, боловсруулах, шалгаж танилцах, дүгнэлт санал гаргах, сумын ИТХ-ын ээлжит болон ээлжит бус хуралдаан, тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал дэвшүүлэн хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтэнд хяналт тавих, биелэлтийг дүгнэх зэргээр ажиллана.

2. Хорооны хурлыг сард нэгээс доошгүй удаа нэгдсэн хуралдаан, нам, эвслийн бүлэг, бусад хороодын хурлын товтой давхцуулахгүйгээр хийх бөгөөд хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалд санал, дүгнэлт өгнө.

3. Хороо нь өөрсдийн хурлаар хэлэлцсэн асуудлаар 1-3 тодорхой зорилт дэвшүүлж сар, улирал тутамд Хурлын Тэргүүлэгчдэд илтгэл тавьж болох ба жил бүрийн үйл ажиллагааны тайланг хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

4. Хороо нь шаардлагатай тохиолдолд өөрсдийн үйл ажиллагааны чиглэлээр мэргэжлийн байгууллага, эрдэмтэн мэргэжилтнүүд, иргэдийг өөрийн ажилдаа орцуулж, оновчтой зөв шийдвэр гаргах бодлого баримталж ажиллана.

5. Хороод өөрсдийн хурлаа нээлттэй, өргөтгөсөн байдлаар иргэдийн төлөөллийг оролцуулахаас гадна иргэдийн оршин суугаа газар болон шийдвэрлэх асуудал ихтэй нутаг дэвсгэрт хурлыг зохион байгуулж болно.

6. Хороод нь ажлын үйл ажиллагаа болон Хурлын тогтоол, шийдвэрийг өөрсдийн хариуцсан үндсэн чиглэлийн дагуу нээлттэй ил тод болгож, мэдээ мэдээллийг иргэдэд хүртээмжтэй хүргэж, сурталчлах бодлого баримталж ажиллана.

Хоёр. Хороодын дарга нар дараах чиглэлээр ажиллана.

1. Хорооны дарга нь тухайн жил, улирлын хийх ажлын төлөвлөгөөг хорооны хурлаар хэлэлцүүлэн, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулна.

2. Хорооны дарга нь хурлаар хэлэлцэх асуудлын талаар санал гаргах, хурлаар хэлэлцэх асуудлыг баталж, хурлыг удирдан явуулна. Хорооны дарга эзгүй үед түүний санал болгосон төлөөлөгч хурлыг удирдан явуулна.

3. Хорооны дарга хамаарах асуудлаар хурал зохион байгуулах санал, дүгнэлт боловсуулахдаа сумын ИТХ-ын тэргүүлэгчдэд танилцуулж саналыг нь авна.

4. Хорооны дарга нар нь хариуцсан асуудлын хүрээнд холбогдох албан байгууллага, газар, хэлтэс, алба, албан тушаалтнуудын үйл ажиллагаатай танилцахаас гадна хамтран ажиллах, мэдээ мэдээлэл гаргуулах, удирдах ажилтан, багийн засаг дарга нарыг дуудаж уулзах, шаардлагатай гэж үзвэл сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд асуудал оруулж шийдвэрлүүлнэ.

5. Эрхлэх асуудлын хүрээнд олон нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж болох ба шаардагдах төсөв, санхүүгийн асуудлыг сумын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчидтэй зөвшилцөнө.

6. Хорооны дарга нар нь өөрийн гишүүдээс тухайн хорооны асуудал хариуцсан зохион байгуулагчийг томилж, Хурлын ажлын албатай нягт уялдаа холбоотой ажиллуулна.

Гурав. Хурлын ажлын алба, зохион байгуулагчдын зүгээс хорооны өдөр тутмын үйл ажиллагааг дараах байдлаар хангана.

1. Хорооны өдөр тутмын үйл ажиллагааг Хурлын ажлын албаны бичиг хэргийн ажилтан тухайн хороо хариуцсан зохион байгуулагчтай хамтран гүйцэтгэж дарга нартай холбоотой ажиллана. Хорооны эрхэлсэн ажлын хүрээнд УИХ-ын байнгын хороод, Аймгийн ИТХ-ын хороодын үйл ажиллагаа болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг судлан хороодын дарга нарт танилцуулна.

2. Хорооны хурлаар хэлэлцэх асуудлыг гишүүдэд нэгээс доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.

3. Хурлын ажлын албаны бичиг хэргийн ажилтан, тухайн хороо хариуцсан зохион байгуулагч хамтран хорооны дарга, төлөөлөгчдийг мэдээ мэдээллээр хангах, хуралд орлцогчдод зар хүргэх, хурлын байрыг бэлтгэх, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтлөн

хорооны даргад танилцуулж, гарын үсэг зуруулан баримтжуулах, хорооноос гарах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах зэрэг ажлыг зохион байгуулна.

4. Хурлын ажлын албаны бичиг хэргийн ажилтан нь хорооны үйл ажиллагаатай холбоотой бичиг баримтыг албан хэрэг хөтлөлтийг стандарт, архивын журам, дүрмийн дагуу боловсруулан хөтөлж, жилийн эцэст хурлын байгууллагын архивт хүлээлгэн өгөх үүргийг гүйцэтгэнэ.

Дөрөв. Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчидийн Хурал дахь нам, эвслийн бүлгүүдтэй дараах байдлаар хамтран ажиллана.

1. ИТХ дахь нам, эвслийн бүлгүүдийн дарга нартай хамтран ажиллаж, хорооны хурлын зар, хэлэлцэх асуудлыг төлөөлөгчдөд хүргэх мэдээ мэдээллээр хангах ажлыг хамтран зохион байгуулна.

2. ИТХ дахь нам, эвслийн бүлгүүдийн дарга нар нь бүлгийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бэлтгэлийг хариуцан ажиллана.

Тав. ИТХ-ын дэргэдэх хороодын эрхлэх асуудал, үйл ажиллагааны үндсэн чиглэл:

1. Хороод нь Баян-Өндөр сумын Засаг даргын жил жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудад санал, дүгнэлт гаргаж, хэрэгжилт, биелэлтэнд хяналт тавихаас гадна дараах асуудлыг хариуцаж ажиллана.

1.1 Хууль зүй, хурал, захиргааны бодлого хэрэгжилтийн хороо.

- Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хурлын дотоод үйл ажиллагаа, төлөөлөгчдийн ёс зүйн асуудал
- Орон нутгийн өмчийн бодлого
- Хууль, эрх зүйн бодлого
- Хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа
- Иргэдийн санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
- Сүм, хийд, шашны байгууллагуудын харилцаа
- Мэдээлэл, технологийн бодлого
- Багуудын хилийн цэсийн асуудал

1.2 Төсөв санхүү, хөрөнгө оруулалтын хороо.

- Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн Засаг даргын үндсэн чиглэлийн төлөвлөлт, хэрэгжилтэнд хяналт тавьж, дэмжих
- Сумын төсөв бүрдүүлэх чиглэлээр Төсвийн тухай хуулийн 23.8 заалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, зарцуулалтанд хяналт тавих
- Сумын төсөв, төсвийн орлого, зарлагад хяналт тавих
- Төсвийн бус орлогоор хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт тавих
- Сумын болон нийтийн зориулалттай өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалт, эд хөрөнгийн түрээслэлтийг хянах
- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөд зайлшгүй шаардлагатай ажил төрлөө явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хуулийн хүрээнд урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх чиглэл баримтлах
- Сумын татварын тогтолцоог бий болгож сайжруулах асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэхийг бодлогоор дэмжих.
- Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон байгууллага, аж ахуйн нэгж, компаниудын салбар сүлжээг орон нутгийн төсөвтэй харьцдаг тогтолцоог бий болгох чиглэл баримтална.

1.3 Монгол хүн 2020, Нийгмийн бодлого, хөгжлийн хороо.

- Монгол хүн 2020 хөтөлбөрийг дэмжих, биелэлтэнд хяналт тавих
- Боловсрол, соёлын талаарх
- Эрүүл мэндийн талаарх
- Биеийн тамир, спорт, урлагийн талаарх
- Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалал
- Хүнсний аюулгүй байдлын талаар баримтлах бодлого
- Хүн ам зүйн бодлого зохицуулалт
- Нийгмийн хамгааллын бодлого

1.4 Үйлдвэрлэл, үйлчилгээ ХАА-н бодлогын хороо.

- “Үйлдвэрлэл технологийн парк”- ын үйл ажиллагааг дэмжих
- Нийтийн ахуйн үйлчилгээ, орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бодлогоор дэмжих
- Газар тариалан , үрийн аж ахуй, хөрсний бохирдолыг тэнцвэртэй байлгах ажлыг эрчимжүүлэх
- Төрөөс малчдын талаар”Монгол мал” малын удмын сан, мал эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт тавих
- Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих ,хөнгөлөлттэй зээл тусламж олгох
- Худалдаа ,үйлчилгээ бизнесийн салбарыг дэмжиж орон нутгийн зах зээлийг хамгаалах бодлого баримтлана.
- Эрчимжсэн мал аж ахуй ,агуулах зоорь ,малчдын нөхөрлөл хоршоо дэмжих

1.5 Дэд бүтэц, Хот тохижилт, байгаль орчин, экологийн хороо.

- дэд бүтэц, барилга байгуулалт, автозам
- хотын үерийн ус зайлуулах систем
- эко хороолол
- байгаль орчны менежмент
- хот тохижилт, гэрэлтүүлэг
- газар зохион байгуулалт, ашигт малтмал
- Хотын орон сууцны ашиглалт
- экологийн талаар хэрэгжүүлж ажлууд

1.6 Гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааны хороо.

- Сумын гадаад, дотоод харилцааг бүх талаар өргөжүүлэх, бодит хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнесийн түншлэлийг шинээр тогтоох,
- Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалтай үйлдвэр, аж ахуйн газруудтай хамтарч ажиллах
- Гадаад харилцаа, хамтын ажиллагааг сурталчилах ажлын арга туршлага солилцох ажлыг зохион байгуулах
- Сумын жилийн төлөвлөгөөнд гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааны талаар санал оруулах, төлөвлөгдсөн ажлуудын хэрэгжилтэнд хяналт тавих



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 26

Эрдэнэт

Багт ажиллах хэсгийн ахлагчдын тоо,
урамшууллыг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Багт ажиллах хэсгийн ахлагчид 1 сард олгох урамшууллыг 100 000 /нэг зуун мянга/ төгрөгөөр тогтоосугай.

2.Багуудын өрх, хүн амын тоог харгалзан, батлагдсан төсөвт багтаан хэсгийн ахлагч нарын тоог тогтоож, урамшууллыг сар бүр олгохыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-т даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 27

Эрдэнэт

**Дэнж, Согоот багийн Амьжиргааг дэмжих
зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9.5 дахь заалт, Дэнж, Согоот багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Дэнж багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Д.Мартыг чөлөөлж, Х.Угтаабаярыг томилсугай.

2.Согоот багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс С.Тунгалаг, М.Болормааг чөлөөлж Д.Дорж, О.Галсмаа нарыг тус тус томилсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 28

Эрдэнэт

Шинээр баригдсан орон сууцны
байруудад хаяг өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Баянцагаан багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Баянцагаан багийн нутаг дэвсгэрт шинээр баригдсан орон сууцны байрыг “Өнөр хотхон” 1, 2 гэж хаяглахаар тогтоосугай.

2.Баянцагаан багийн “Өнөр хотхон” 1, 2 дугаар орон сууцны байрын хаягжилт, иргэдийн хаягийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхийг сумын Засаг дарга /И.Баасанжав/, Баянцагаан багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч /Х.Мөнхбаяр/ нарт даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 29

Эрдэнэт

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Уртбулаг багийн өндөр настан Шаравжамцын Бээжинхүү, Уурхайчин багийн өндөр настан Дэндэвийн Хумхааш нарыг Төрийн дээд шагнал “Алтан гадас одон”-оор шагнуулахаар шийдвэрлэж Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай.

ДАРГА

Н. ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 30

Эрдэнэт

Сумын Засаг даргын нөөц санг зарцуулах,
хяналт тавих журмыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1.2-ын “б” заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын нөөц санг зарцуулах хяналт тавих журмыг хавсралтаар баталсугай.

2. Нөөц санг журмын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг улирал бүр Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-т даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА

Н. ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 31

Эрдэнэт

**Багуудын Иргэдийн Нийтийн хурлын
хуралдааны тов зарлах тухай**

Монголын Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 22 дугаар зүйлийн 22.1, 22.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн “Чиглэл өгөх тухай” 04 дүгээр тогтоол, сумын Засаг даргын саналыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багийн Иргэдийн Нийтийн хурлын дарга, Тэргүүлэгчид, багийн Засаг дарга нарыг сонгох багийн Иргэдийн Нийтийн хурлын хуралдааныг 2013 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулахаар товолсугай.

2.Багуудын Иргэдийн Нийтийн хурлын хуралдааныг хуралдуулах байр, өдөр, цагийн хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

3.Багийн Иргэдийн Нийтийн хурлын хуралдааны бэлтгэл ажлыг сайн хангаж, хуулийн дагуу зохион байгуулахыг Баян-Өндөр сумын Засаг дарга /И.Баасанжав/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 32

Эрдэнэт

**Багуудын Иргэдийн Нийтийн хурлын
хуралдааны тов зарлах тухай**

Монголын Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 22 дугаар зүйлийн 22.1, 22.1.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн “Чиглэл өгөх тухай” 04 дүгээр тогтоол, сумын Засаг даргын саналыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багийн Иргэдийн Нийтийн хурлын дарга, Тэргүүлэгчид, багийн Засаг дарга нарыг сонгох багийн Иргэдийн Нийтийн хурлын хуралдааныг 2013 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулахаар товлосугай.

2.Багуудын Иргэдийн Нийтийн хурлын хуралдааныг хуралдуулах байр, өдөр, цагийн хуваарийг хавсралт ёсоор баталсугай.

3.Багийн Иргэдийн Нийтийн хурлын хуралдааны бэлтгэл ажлыг сайн хангаж, хуулийн дагуу зохион байгуулахыг Баян-Өндөр сумын Засаг дарга /И.Баасанжав/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 33

Эрдэнэт

Ажлын төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс 2013 оны хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Ажлын төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьж, дүнг Тэргүүлэгчдэд танилцуулахыг Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /С.Өлзийсайхан/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 34

Эрдэнэт

**ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны
дотоод журам батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны дотоод журмыг хавсралтаар баталсугай.

2.Дотоод журмыг мөрдөж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны даргад үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2013 оны 03 сарын 07 өдрийн хуралдааны
34 дугаар тогтоолын 1-р хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Хөдөлмөрийн дотоод журмын зорилго нь төрийн албыг шуурхай үр дүнтэй удирдах, оновчтой зөв зохион байгуулах, төрийн албан хаагчаас албан үүрэгтээ чадварлаг, идэвхи санаачлагатай хандаж үйл ажиллагааг төрийн албаны стандартын дагуу явуулах, төрийн алба явуулахтай холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

ИТХ нь хөдөлмөрийн харилцаанаас үүссэн тодорхой асуудлууд болон төрийн албан хаагчдын төрийн алба хаахтай холбогдсон бусад харилцааг Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудыг үндэслэн энэхүү дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.

Хоёр. ИТХ-ын үүрэг

Төрийн албаны стандартыг мөрдөж, төрийн албан хаагчдыг шуурхай удирдлагаар ханган үйл ажиллагааг оновчтой зохион байгуулж, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг хэрэгжүүлж ажиллана.

Байгууллагын дотоод дэг журам зохион байгуулалт тохижилтыг сайжруулж, ажиллагсдыг ажиллах нөхцөл нийгмийн баталгаагаар хангана. Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга /Ерөнхий менежер/ баталж мөрдүүлж ажиллана.

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дагуу ерөнхий менежер тухайн төсвийн жилд нийлүүлэх нийт бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг тодорхойлж төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн захиргааны албан хаагчидтай бүтээгдэхүүн нийлүүлэлт үр дүнгийн гэрээг байгуулж, хагас бүтэн жилээр дүгнэн үнэлгээ өгнө.

Ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар жил бүр бодлого төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. Амьжиргааны баталгаажих түвшингээс

доогуур орлоготой болон гачигдал зовлон тохиолдсон ажиллагсдад зохих дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

Цалинг ажилласан жил, зэрэг дэв, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, үр дүнгийн гэрээний үнэлгээ, ур чадварыг үндэслэн олгоно. Төрийн захиргааны албан хаагчид, ажиллагсдыг мэргэшил, ур чадвараа дээшлүүлэх, сургалтанд хамрагдах нөхцлөөр хангана. Үүнд:

Төрийн албан хаагчдыг сургах мэргэшүүлэх төлөвлөгөөний дагуу төрийн удирлагын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх, давтан сургалтанд явахад албан тушаалын цалинг олгож, албан томилолт, унааны зардлыг Санхүү эдийн засгийн яамны сайдын баталсан журмыг баримтлан олгоно.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг ажлын байрны тодорхойлолт, үр дүн, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, төрийн албаны хуулийн дагуу үнэнч шударга хөдөлмөрлөж чадаж байгаа эсэхэд хяналт тавина.

Гурав. Албан хаагчийн эрх үүрэг

1. Иргэн нь төрийн албанд орохдоо хөдөлмөрийн гэрээ байгуулна. Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамтай танилцаж гарын үсэг зурна.

2. Төрийн албан хаагч нь төрийн албан хаагчийн ёс зүйг эрхэмлэн, хуулиа дээдлэн сахин биелүүлж, албан үүргээ гүйцэтгэхдээ Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхэд холбогдон гарсан бусад эрхийн акт, төрийн захиргааны албан тушаалын ёс зүйн хэм хэмжээний тухай дүрэм, хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөх ба хуулиар тогтоосон бусад эрх үүргээ хэрэгжүүлж, хариуцлагатай идэвхи санаачлагатай шударга ажиллана.

3. Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээнд заасан нийт болон тусгай захиалгат бүтээгдэхүүнийг тоо хэмжээ, чанарын үзүүлэлтээр нийлүүлж тайланг улирал бүр гаргаж ирүүлнэ.

4. Хууль эрх зүйн болон мэргэжил, мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж, нийтээр дагаж мөрдөх, заавал мэдвэл зохих, эрхэлсэн ажил үүрэгтэй холбогдох эрхийн актын жагсаалт гарган мөрдүүлж ажиллана.

5. Байгууллагаас зохион байгуулж байгаа арга хэмжээнд идэвхитэй оролцож, тодорхой хувь нэмэр оруулна.

6. Эзэмшиж байгаа ажлын байр, эд хогшил, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу хамгаалж ариг гамтай эзэмшинэ.

7. Байгууллагын болон эрхэлж байгаа ажил албан тушаалтай холбогдсон нууцыг хадгална.

8. Гэрээгээр ажиллагсад гэрээнд заасан нөхцөл үүргийг биелүүлнэ.

Дөрөв. Иргэдийг төрийн захиргааны албан тушаалд авах, чөлөөлөх

1.Төрийн захиргааны албан хаагчийг ажилд авахдаа Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2003.02.27-ны 04 тоот тогтоолд заасны дагуу ажилд авна.

2. ИТХ тухайн иргэнтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр хөдөлмөрийн гэрээг 2% үйлдэж, ИТХ-ын Тэргүүлэгчид тогтоол гарган албан тушаалд томилно.

3. Иргэнийг төрийн захиргааны албан тушаалд авахдаа 6 сарын хугацаатай, төрийн үйлчилгээний албан тушаалд 3 сарын хугацаатай түр томилон ажиллуулна. Туршилтын хугацааг шаардлагатай гэж үзвэл дахин дээрх хугацаагаар сунгаж болно.

4. ИТХ-аас төрийн албанд шинээр орсон ажилтанд дараах баримт бичгийг танилцуулна. Үүнд:

а.Ажилтны гүйцэтгэх ажлын байрны тодорхойлолт, нийлүүлэх бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ ажил үүргийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлс шагнал урамшуулал олгох журам, эрх үүрэг.

б.Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон тухайн ажил албан тушаалд шаардлагатай бичиг баримтууд.

1. Ажилтан өөрөө хүсэх буюу ажлын хариуцлага алдвал ИТХ-ын Тэргүүлэгчид, ажилтантай байгуулсан Хөдөлмөрийн гэрээг төрийн албаны тухай хуулийн 23, 24, 25, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 5.1.3, 17.1.12, Хөдөлмөрийн тухай хуулийн 37, 38, 39, 40 дүгээр зүйлийн заалтуудыг үндэслэн холбогдох арга хэмжээг авна.

2. Ажлаас чөлөөлөгдсөн ажилтан хариуцаж байсан албан хэрэг, баримт бичиг, эд хогшил, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд материалыг бүрэн бүтэн хүлээлгэж өгсний дараа тооцоо хийнэ. Маргаан гарвал шүүхээр шийдвэрлүүлнэ.

Тав. Ажил амралтын цаг

1.Төрийн албан хаагчдын ажил, амралтын цагийг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ энэхүү дотоод журмын үндсэнд зохицуулна.

2.Албан хаагчдыг хөдөлмөрийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу 7 хоногт 40 хүртэл цаг ажиллуулна.

3. Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цаг байна.

4. Албан хаагчийг хөдөлмөрийн тухай хуулийн 74 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд илүү цагаар ажиллуулахыг хориглоно.

5. Ажилтанд, тэдний гэр бүлд гачигдал, хүндэтгэн үзэх шалтгаан тохиолдсон үед түүний хүсэлтээр 21 хүртэл өдрийн захиргааны цалингүй чөлөө олгоно.

6. Шинээр гэр бүл болсон, хүүхэд төрсөн үед ажлын 5 өдрийн, хагацал зовлон тохиолдсон ажилтанд 10 хүртэлх хоногийн чөлөөг цалинтай олгож болно. Цалинтай, цалингүй чөлөөнөөс шалтгаангүйгээр хожимдвол ажил тасалсанд тооцно.

Зургаа. Тусламж, тэтгэлэг, тэтгэмж

1.Ажиллагсад нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу ажиллах нөхцөл нийгмийн баталгаагаар хангагдаж, 29, 30 дугаар зүйлд заасны дагуу хөнгөлөлт, нөхөн төлбөр, тусламж олгоно.

2. Төрийн албан хаагчдын цалин хөлснөөсөө төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн 10% хувийг байгууллагын төсвөөс төлнө.

3. Ээлжийн амралтаараа өөрийн буюу эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутаг явах хүмүүсийн ирэх очих унааны зардлыг автомашин, төмөр замын тээврийн энгийн үнэлгээгээр тооцож, зохих баримтыг үндэслэн 2 жил тутамд нэг удаа олгоно.

4. Төрийн албан хаагчдийн дунд соёл урлаг, биеийн тамир спортын уралдаан тэмцээн, хамт олныг хамарсан туршлага солилцох, аялал жуулчлалд явах зэрэг арга хэмжээ зохион байгуулах зардлыг төсвөөс гаргана.

5. Гэр хороололд амьдардаг ажилтнуудад ажилдаа ирэх очихын унааны зардлын хөнгөлөлт үзүүлнэ.

6. Хүнд өвчний улмаас өөрөө буюу эхнэр /нөхөр/ нь 2 сараас дээш хугацаагаар өвчлөх, өвчтэй хүүхдээ асрах тохиолдолд ар гэрийн гачигдлыг харгалзан нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламжийг жилд нэг удаа олгоно.

7. Байгууллагад ажиллаж байсан өндөр настан ахмадуудад Цагаан сар, ахмадын өдрөөр 30000 хүртэл төгрөгийн тусламж, дурсгалын зүйл өгнө.

Долоо. Шагнал урамшуулал

1.Төрийн албанд тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж, ажлын амжилт гаргасан төрийн албан хаагчид, ажиллагсдыг шагнаж урамшуулах арга хэмжээ авна. Үүнд:

а/ Монгол улсын төрийн дээд цол, одон медаль, тухайн салбарын түүний ажилтан аймаг, орон нутгийн шагналд журмын дагуу тодорхойлох

б/ Сумын хүндэт дэвтэрт бичиж алдаршуулах, урамшуулах

2. Төрийн захиргааны албан хаагчдын бүтээгдэхүүн нийлүүлэлт, үр дүнгийн гэрээг хагас бүтэн жилээр үнэлж дүгнэсэн үнэлгээний дүнг үндэслэн жилийн эцэгт цалингийн хэмнэсэн зардлаас нэмэгдэл урамшуулал олгож болно.

3. Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журмын дагуу шалгуур үзүүлэлтээр улирал бүр оноо өгч үзүүлэлтүүдийн:

85%-89%-д хангалттай үнэлгээг авсан бол 15%-иар

90%-94%-д хангалттай үнэлгээг авсан бол 20%-иар

95-аас дээш хувьд хангалттай үнэлгээг авсан бол 25%-иар цалингийн нэмэгдэл олгоно.

Найм. Сахилга хариуцлага

1.Төрийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлд заасныг зөрчсөн, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дүрэм, дотоод журам, хөдөлмөрийн гэрээ болон хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн, төрийн захиргааны ба үйлчилгээний албан хаагчдад сахилгын шийтгэл оногдуулна.

2. Ажилтан дор дурьдсан зөрчлийг гаргавал хөдөлмөрийн сахилга зөрчсөнд тооцно. Үүнд:

а/ Хүндэтгэж үзэх шалтгаангүйгээр ажил таслах

б/ Ажлын цагаас хоцрох, өмнө явах /30-аас дээш минут/

в/ Удирдлагын зөвшөөрөлгүй гүйцэтгэж байсан ажил үүргээ орхих, ажлын цагийг үр бүтээлгүй ашиглах

г/ Төрийн ба албан хаагчийн үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй

д/ Нийт болон тусгай захиалгат бүтээгдэхүүний тайланг хугацаа хоцроосон, тасалдуулсан

- е/ Бусдын ажилд саад хийх, дарамт үзүүлэх
- ё/ Ажлын чиглэлээр гаргах мэдээ судалгаа тайланг хугацаа хоцроох, санаатай буруу гаргах
- ж/ Байгууллагын болон хариуцсан эд хөрөнгө, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг эвдэж хэмхлэх, үрэгдүүлэх, буруугаар ашиглах
- з/ Албан бичиг баримтыг хувийн зорилгоор ашиглах
- и/ Төрийн албаны болон эрхэлж байгаа ажил албан тушаал, хувь хүний нууцыг хадгалах, хамгаалах журам зөрчих
- й/ Тамга, тэмдэгийн талаар журам зөрчих
- к/ Албан тушаалаа урвуулан ашиглах
- л/ Хууль бусаар шан харамж авах, авилгалд өртөх
- м/ Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм зөрчих
- н/ Иргэдтэй зүй бусаар харьцах, чирэгдүүлэх
- о/ Ажилдаа согтуу /үнэртүүлэх/ ирэх, ажлын цагаар болон ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх

3. Сахилгын зөрчил гаргасан ажиллагсдад дараах шийтгэл оногдуулна.
Үүнд: а/ Сануулах

б/ Албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 % хүртэл бууруулах

в/ Төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.

4. Төрийн албан хаагч удаа дараа үүргээ хангалтгүй биелүүлсэн, Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, дотоод журыг удаа дараа зөрчсөн бол Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 1.1-р заалтыг үндэслэн ажлаас халах

5. Хүндэтгэж үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш хоног ажил тасалсан, дотоод журмын сахилгын зөрчил тооцох ё, ж, з, и, к, л, м, н, о заалтыг зөрчсөн тохиолдолд Хөдөлмөрийн хуулийн 38, 39, 40, 131-ыг тус тус үндэслэн шууд хөдөлмөрийн гэрээг цуцлана.

6. Ажилтан өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд хохирлыг барагдуулан журмын дагуу хариуцлага хүлээнэ.

7. Төрийн захиргааны албан хаагчидтай хариуцлага тооцохдоо Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, дотоод журмыг, төрийн үйлчилгээний албан хаагчидтай хариуцлага тооцохдоо Хөдөлмөрийн хууль, дотоод журмыг баримтлана.

Ес. Бусад зүйл

- 1.Энэхүү дотоод журмыг Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж олонхи зөвшөөрснөөр батална.
- 2.Энэхүү дотоод журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэй.
- 3.Шинээр гаргасан хууль тогтоомжийг үндэслэн тухай бүр өөрчлөлт оруулж боловсронгуй болгон ажилтнуудад мэдэгдэнэ.

оОо



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 34/а

Эрдэнэт

Дипломат болон албаны гадаад паспорт
гаргуулах тухай

Ажлын шаардлагыг харгалзан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Намнангийн
Жаргалсайханд дипломат болон албаны гадаад паспорт олгуулахаар Гадаад
хэргийн яаманд хүсэлт болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 35

Эрдэнэт

**СИТХ-ын ээлжит IV хуралдаан зарлан
хуралдуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэхь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

НЭГ. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит IV хуралдааныг 2013 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зарлан хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцэхээр тогтоосугай. Үүнд:

1. Газар зохион байгуулалт
2. Бусад асуудал

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 36

Эрдэнэт

Арга хэмжээ авах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалт, Хууль зүй, хурал захиргааны бодлого хэрэгжилтийн хорооны дүгнэлт, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1.Оюут, Согоот, Рашаант багуудын ИНХ-ын дарга нарын 1 сарын урамшууллыг 100% хасаж сахилгын шийтгэл ногдуулан, Согоот багийн зохион байгуулагч Н.Дэлгэрмаад арга хэмжээ тооцож хариу мэдэгдэхийг Засаг даргын Тамгын газрын дарга З.Эрдэнээд үүрэг болгосугай.

2.Оюут, Согоот, Рашаант багуудын ИНХ-ын дарга нарын урамшууллыг 3 дугаар сарын урамшууллаас хасаж тооцохыг ня-бо /Г.Бүдхүү/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 37

Эрдэнэт

**СИТХ-ын ээлжит бус IV хуралдааны
товыг хойшлуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалтыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит IV хуралдааныг 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зарлан хуралдуулахаар хойшлуулсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 38

Эрдэнэт

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дугаар зүйл, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай. Үүнд:

Монгол улсын Гавъяат багш цолоор:

1. Дамбын Аюурзана	Орхон аймгийн “Баян-Өндөр” цогцолбор сургуулийн хөгжмийн багш, сургалтын менежер
--------------------	--

Аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор:

1. Бямбын Чулуунбат	“Эрдэнэт Булганы Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Ерөнхий инженер
---------------------	--

Алтан гадас одонгоор:

1. Бямбасүрэнгийн Эрдэнэчимэг	14-р сургуулийн Бага ангийн багш
2. Төмөр-Очирын Мөнхжаргал	7-р сургуулийн Биеийн тамирын багш

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

1. Алтангэрэлийн Болормаа	Орхон аймгийн “Баян-Өндөр” цогцолбор сургуулийн бага ангийн багш
---------------------------	--

2.Ширхээгийн Дорж	14-р сургуулийн Математикийн багш, сургалтын менежер
3.Очирхүүгийн Энхжаргал	14-р сургуулийн Орос хэлний багш
4.Гэндэндарамын Байгалмаа	14-р сургуулийн Орос хэлний багш
5.Рэнцэндоржийн Должинсүрэн	14-р сургуулийн Математикийн багш
6.Очирбатын Цэрэндулам	14-р сургуулийн Биеийн тамирын багш

Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор:

1.Дашийн Хишигдорж	Өндөр настан
--------------------	--------------

Алтан гадас одонгоор:

1.Еришийн Гафу	Өндөр настан
2.Пүрэвийн Түвшинбаяр	Өндөр настан
3.Цэдэнгийн Биньяа	“Буян” элэг цөсний хувийн эмнэлэгт зөвлөх эмч
4.Тасранжавын Банзардарь	Өндөр настан
5.Санжсүрэнгийн Должинсүрэн	Өндөр настан
6.Аюушжавын Лхагвасүрэн	Өндөр настан
7.Батбаярын Батцогт	Өндөр настан
8.Батын Базардарь	Өндөр настан
9.Шуухуузын Халтар	Өндөр настан
10.Даржаагийн Равдан	Өндөр настан

Цэргийн хүндэт медалиар:

1.Цэрэндоржийн Сэрээтэрдорж	Дотоодын цэргийн 816-р ангид Аж ахуйн эрхлэгч
2.Хар-Өвгөний Баатар	Дотоодын цэргийн 816-р ангид Харуулын дарга



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 39

Эрдэнэт

Зарим багуудын Иргэдийн нийтийн хурлын
Хуралдааныг дахин хуралдуулах тов зарлаж
хуваарь батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багуудын Иргэдийн нийтийн хурлын хуралдаанаар багийн ИНХ-ын дарга сонгохдоо тамга тэмдэг, гарын үсэггүй саналын хуудсаар санал авсан Их залуу баг, Засаг даргад нэр дэвшиж 50-иас дээш хувийн санал аваагүй Шанд, Говил багуудын Засаг даргад нэр дэвшүүлэх хурлыг 2013 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр дахин хуралдуулж, хуваарийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2.Хуралдааны бэлтгэл ажлыг сайн хангаж, хуулийн дагуу зохион байгуулахыг Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга /З.Эрдэнээ/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
Тэргүүлэгчдийн 2013 оны 04 сарын 02-ны
өдрийн 39 -р тогтоолын хавсралт

БАГИЙН ИНХ-ЫН ХУРАЛДААНЫ ХУВААРЬ

№	Багийн нэр	Хурал болох байр	ИНХ болох сар, өдөр	Цаг	Хариуцах эзэн
1	Говил	2-р сургууль	IV/06	11.00	Б.Алтаншагай Д.Хөвсгөл Д.Сайнбилэг
2	Их залуу	3-р сургууль	IV/06	11.00	Л.Бадамхорлоо С.Наранцэцэг Ц.Дэмчигжав
3	Шанд	17-р сургууль	IV/06	11.00	П.Гантуяа Б.Батхүү Б.Батзаяа

оОо



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 40

Эрдэнэт хот

Шинээр баригдсан орон сууцны
байруудад хаяг өгөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Баянцагаан багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянцагаан багийн нутаг дэвсгэрт шинээр баригдсан орон сууцны байрыг “Өнөр хотхон” 1, 2 гэж хаяглахаар тогтоосугай.

2. Баянцагаан багийн “Өнөр хотхон” 1, 2 дугаар орон сууцны байрын хаягжилт, иргэдийн хаягийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхийг Сумын Засаг дарга /И.Баасанжав/, Баянцагаан багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч /Х.Мөнхбаяр/ нарт даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 41

Эрдэнэт

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дугаар зүйл, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай. Үүнд:

Монгол улсын Гавъяат багш цолоор:

- | | |
|----------------------------|---|
| 1. Цэрэндоржийн Наранцэцэг | Орхон аймгийн 14-р сургуулийн химийн багш |
|----------------------------|---|

Монгол улсын Соёлын гавъяат зүтгэлтэн цолоор:

- | | |
|-------------------------|-------------------------|
| 1. Ягааны Баянмөнх | Тэтгэвэрт |
| 2. Начингийн Даваасүрэн | Шагайн холбооны тэргүүн |

Монгол Улсын Гавъяат тээвэрчин цолоор:

1. Сандагийн Хадбаатар

Замын хөдөлгөөний дүрэм, жолооны багш

Монгол Улсын Гавъяат Барилгачин цолоор:

1. Моломын Ичинхорлоо

Тэтгэвэрт

Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор:

1. Дамдинсүрэнгийн Долгорсүрэн

Тэтгэвэрт

Алтан гадас одонгоор:

1. Пүрэвжавын Наранцэцэг

“Ийгл” дунд сургуулийн захирал

2. Доржийн Сайнбуян

7-р сургуулийн түүх нийгмийн ухааны багш

3. Баасанчоймболын Төмөрбаатар

“Наран” цогцолбор сургуулийн гүйцэтгэх захирал

4. Пунцагийн Даваацэнд

“Наран” цогцолбор сургуулийн бага ангийн багш, сургалтын менежер

5. Загдын Бурмаа

“Наран” цогцолбор сургуулийн бага ангийн багш

6. Цэвэгжавын Батсуурь

“Наран” цогцолбор сургуулийн бага ангийн багш

7. Бүдийн Баасанхүү

14-р сургуулийн бага ангийн багш

8. Дагвын Жавхлан

21-р цэцэглэгийн багш

9. Баасанбаагийн Болдбаатар

2-р сургуулийн биеийн тамирын багш

10. Гэндэндоржийн Хишигжаргал

“Эрдэнэт хивс” ХХК-ийн хангамжийн албанд нярав

11. Жанчивын Гангаамаа

“Эрдэнэт хивс” ХХК-ийн мастер

12. Дэлгэрийн Жавзан

“Эрдэнэт хивс” ХХК-ийн ХАБЭА-н асуудал
хариуцсан ажилтан

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

1. Пүрэвийн Нямсүрэн

“Наран цогцолбор” сургуулийн биологийн
багш

2. Бямбажавын Батсүх

“Цайхун гэгээ” сургуулийн сургалтын
менежер, математикийн багш

3. Сурмаажавын Батнайрамдал

“Эрдэнэт хивс” ХХК-ийн Засварчин, туслах
мастер

4. Дүгэрсүрэнгийн Сайнбаяр

“Эрдэнэт хивс” ХХК-ийн Ноос угаах
үйлдвэрийн дарга

5. Шархүүгийн Сарантуяа

“Эрдэнэт хивс” ХХК-ийн Угалз үйлдвэрийн
даргаар ажиллаж байсан

6. Жамсранжавын Болормаа

“Эрдэнэт хивс” ХХК-ийн Үйлдвэрлэлийн
инженер

7. Тогтох Эрдэнэчимэг

“Эрдэнэт хивс” ХХК-ийн Нэхэгч, Лаборант

8. Гэндэнжанхарын Оюунцэцэг

“Эрдэнэт хивс” ХХК-ийн Материалын болон
гадаад, дотоод байгууллагын тооцоо
хариуцсан нягтлан бодогч

9. Батаагийн Наранцэцэг

“Эрдэнэт хивс” ХХК-ийн Ерөнхий нягтлан
бодогч

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 42

Эрдэнэт

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.20 дахь заалт, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дор дурдсан хүмүүсийг “Алдарт эх I, II одон”-оор шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай. Үүнд:

Алдарт эхийн I одонгоор:

- | | |
|------------------------------|---|
| 1. Дорж Бадамхүү | Баянбулаг баг Баян-Өндөрийн 2-07 тоот |
| 2. Хаянхирваа Лхагваа | Баянбулаг баг Баян-Өндөрийн 1-31 б тоот |
| 3. Лхагва Ууганцэцэг | Баянцагаан багийн дцс -34 |
| 4. Бат Цагаанчулуун | Булаг 10-10 |
| 5. Валя Ариунгэрэл | Говил баг Илгээлт А-41 тоот |
| 6. Лодон Пагма | Говил баг Илгээлт А-3 тоот |
| 7. Раднаабазар Эрдэнэсүвд | Говил баг Чулуут 39-Г тоот |
| 8. Лувсан-Ёндон Нарангэрэл | Зүүн дэнж 2-10 тоот |
| 9. Ламзавын Жунай | Их залуу баг баруун задгай 4-04 тоот |
| 10. Нарантуяагийн Пагамдулам | Их залуу баг хабитатын 12А-13 тоот |
| 11. Ханджавын Цэрмаа | Их залуу баг их залуу 10А-05 тоот |

12. Мэнгээ Баттөмөр	Ингэт баруун гол
13. Ламжав Нарангэрэл	Рашаант 1-26
14. Балсанжав Норжмаа	Рашаант 37-13
15. Дагва Дамдингив	Уртбулаг 5-1-101
16. Доржготов Таяа	Уурхайчин 3-13-46
17. Дагвадорж Баасансүрэн	Хүрэнбулаг 4-8-28
18. Чагдавын Долгор	Хүрэнбулаг 4-23-41
19. Доржийн Цэнджав	Хүрэнбулаг 4-5-14
20. Цогт Орхон	Цагаанчулуут 52-9
21. Дамдинсүрэн Алтанцэцэг	Шанд 34-02
22. Лувсанцэрэн Балсанжав	Шанд 1-2а
23. Лхамсүрэн Дэжээхүү	Шанд 8-20
24. Дийгэн Сүрэн	Шанд 12-12
25. Мядаг Батцоож	Эрдэнэ 22а-8
26. Ондоохүү Отгонбаатар	Эрдэнэ 19а-1
27. Давааням Цэцгээ	Эрдэнэ 25б-1

Алдарт эхийн II одонгоор:

1. Пунцаг Батгэрэл	Баянбулаг баг Баян-Өндөрийн 3-229 тоот
2. Сүхбазар Баянзул	Баянбулаг баг Баян-Өндөрийн 2-85 б тоот
3. Баатар Овдог	Баянбулаг баг Баян-Өндөрийн 2-61 тоот
4. Равдан Пунсалдулам	Баянбулаг баг Баян-Өндөрийн 2-61 тоот
5. Жамбал Авирмэд	Баянцагаан багийн вокзалын 3-32
6. Санчиндорж Ариунсайхан	Баянцагаан багийн шинэ хороо 17-4
7. Хадир Нуржан	Баянцагаан багийн хуучин хороо 5-18
8. Батхуяг Одонтунгалаг	Баянцагаан багийн шинэ хороо 4-1 тоот
9. Баярсайхан Тунгалагсайхан	Баянцагаан баг вокзалын ар 1-18
10. Батсүхийн Ууганцэцэг	Баянцагаан баг вокзалын ар 1-14
11. Дэмбэрэлдаш Алтанцэцэг	Булаг 24-8
12. Жамган Дорлигжав	Булаг 20-8
13. Буриад Оюунгэрэл	Булаг 22-10
14. Гомбосүрэн Сонгууль	Булаг 8-5

15. Чулуунбаатар Хишигсүрэн	Булаг 41-10
16. Гунгаасамбуу Энхтуяа	Булаг 24-8
17. Бадамын Алтансүвд	Бүрэнбүст баг 5-14-41 тоот
18. Аюурсэдийн Саруултуяа	Бүрэнбүст баг 5-15-77 тоот
19. Эрхэмбаярын Тодноо	Бүрэнбүст баг 5-8-22 тоот
20. Сүхбат Адъяа	Говил баг булагт 6-1-3 тоот
21. Дагва Алтанцэцэг	Говил баг 100 айл 19-а тоот
22. Лайгансүрэн Алтанцэцэг	Говил баг булагт-в-2-5 тоот
23. Жамбалдорж Байгалмаа	Говил баг булагт-в-2-16 тоот
24. Дашрэнцэн Ганчимэг	Говил баг Хонхор 26-7 тоот
25. Лувсандорж Мягмаржав	Говил баг Гэр хороолол 3-27 тоот
26. Жамбалдорж Намсрайжав	Говил баг Гэр хороолол 2-8 тоот
27. Балдансүрэн Оргилмаа	Говил баг булагт-в-2-15 тоот
28. Лхасүрэн Хүрэлтуяа	Говил баг Хонхор 35-6 тоот
29. Сүхбаатар Янжинлхам	Говил баг Дэнж 24-3 тоот
30. Цэрэндорж Ариунаа	Баруун дэнж 16-14 тоот
31. Баатар Ариунтунгалаг	Баруун дэнж 25-1 тоот
32. Басан Энхээ	Зүүн дэнж 3-32 тоот
33. Ганбаатар Эрдэнэчимэг	Баруун дэнж 7-2 тоот
34. Дамдинсүрэн Ганчимэг	Зэст баг 1-р хороолол 14-р байр 35 тоот
35. Туваандорж Долгор	Зэст баг 1-р хороолол 4-р байр 12 тоот
36. Батмөнх Ербиш	Зэст баг 1-р хороолол 17-р байр 44 тоот
37. Лхагважав Уламбаяр	Зэст баг 1-р хороолол 3-р байр 22 тоот
38. Доржготовын Болор-Эрдэнэ	Их залуу баг баруун задгай 14-07 тоот
39. Норжмаагийн Бямбасүрэн	Их залуу баг хабитатын 12А-11 тоот
40. Бадамцэрэнгийн Гантуяа	Их залуу баг шандын 18-14 тоот
41. Намжилжавын Гүндэгмаа	Их залуу баг Их залуу 7Б-05 тоот
42. Хишигсүрэнгийн Жаргалмаа	Их залуу баг Их залуу 14А-01 тоот
43. Сүрэнхүүгийн Одончимэг	Их залуу баг хабитатын 4Б-17 тоот
44. Сосорбарамын Оюун	Их залуу баг Их залуу 31Б-10 тоот
45. Тэрбишийн Оюунцэцэг	Их залуу баг баруун задгай 11-01 тоот
46. Буян-Өлзийн Смпилдолгор	Их залуу баг хабитатын 4А-18 тоот
47. Буудайн Саранцэцэг	Их залуу баг их залуу 11Б-01 тоот
48. Цэдэвийн Туул	Их залуу баг баруун залгай 19-08 тоот

49. Аюушийн Хишигжаргал	Их залуу баг шандын 20-01 тоот
50. Рэнцэнгийн Цэнд-Аюуш	Их залуу баг баруун задгай 19-16 тоот
51. Доржсүрэнгийн Чанцалдулам	Их залуу баг их залуу 4А-11 тоот
52. Дорждангийн Эрдэнэбилэг	Их залуу баг Шандын 19-5А тоот
53. Мөнх-Эрдэнийн Эрдэнэчимэг	Их залуу баг Шандын 25-31 тоот
54. Баасанхүү Алтанцэцэг	36-н тоочик
55. Гомбосүрэн Баасанжав	Мангирт
56. Жигжид Батцэцэг	Ингэт гол
57. Мягмарсүрэн Батчимэг	Гээг
58. Гүнтэв Бумжаргал	Ханхар
59. Памбага Даваасүрэн	Дэнж 6-30-12
60. Жумдай Дэлгэр	Ханхар
61. Санжсүрэн Гэрлээ	Ингэт
62. Соном Отгонбаяр	Хонгор овоо
63. Гоомарал Цообаяр	Бургааст булаг
64. Маамуу Ууганцэцэг	Арцат
65. Батчулуун Пүрэвсүрэн	Малчин
66. Пүрэвсүрэн Эрдэнэтуяа	Зүйл
67. Түвшин Эрдэнэчимэг	Тугалч
68. Чулуун Алтанцэцэг	Наран баг 71-12
69. Жавхан Мөөг	Наран баг 26-12
70. Шар Осор	Наран баг 5-05
71. Даваасамбуу Оюун-Эрдэнэ	Наран баг 21-03
72. Эрдэнэбилэг Уранбилэг	Наран баг 7-06
73. Сүхбаатар Бүрэнцэцэг	Оюут баг 2-р хороолол 26-р байр 47-тоот
74. Сосорбурам Нарантуяа	Оюут баг 2-р хороолол 9-р байр 36-тоот
75. Жүгдэрнамжил Наранхүү	Оюут баг 2-р хороолол 25-р байр 19-тоот
76. Чоён Отгондаваа	Оюут баг дөмөг 41 тоот
77. Шарав Батцэцэг	Рашаант 35-6
78. Бямбадаш Золжаргал	Рашаант 33-12
79. Равдан Мөнхжаргал	Рашаант Уртын гол 5-28
80. Пүрэвдорж Мөнхцэцэг	Рашаант Уртын гол 7-9
81. Бямба Оюундэлгэр	Рашаант 2-5
82. Оюумаа Сайнзаяа	Рашаант УГ-22-41

83. Мөнхөө Тогоосүрэн	Рашаант Уртын гол 4-37
84. Төрөө Туяацэцэг	Рашаант 25-13
85. Өлзий Уранчимэг	Рашаант 18-2
86. Баасан Хишигт	Рашаант Уртын гол 12-16
87. Оюумаа Хулан	Рашаант 2-2
88. Лхамноржин Цэцэгжаргал	Рашаант 11-1
89. Оролзод Чулуунцэцэг	Рашаант 39-12
90. Дашням Дашдулам	Рашаант 1-29
91. Янжин Оюунтунгалаг	Согоот 6-10-76
92. Балжинням Оюунтуяа	Согоот 6-12-74
93. Пүрэв Оюунчимэг	Согоот 6-5-34
94. Чулуунсүрэн Эрдэнэцэцэг	Согоот 6-13-46
95. Батцогт Эрдэнэчимэг	Согоот 6-13-64
96. Дэндэв Эрдэнэчимэг	Уртбулаг 5-4-37
97. Түндэв Алтанчимэг	Уурхайчин 3-17-46
98. Түмэнбаяр Баясгалан	Уурхайчин 3-16-73
99. Сүрэнхорлоо Золзаяа	Уурхайчин 3-23-100
100. Дорждан Наранцэцэг	Уурхайчин 3-12-148
101. Дашдондов Өлзийхишиг	Уурхайчин 3-7-3
102. Магсар Сайнжаргал	Уурхайчин 3-9-54
103. Гонгор Цолмон	Уурхайчин 3-8-3
104. Амарсанаа Жавзандулам	Хүрэнбулаг 4-5-42
105. Банзаарай Отгонсайхан	Хүрэнбулаг 4-14-113
106. Бямбажав Сурмаа	Хүрэнбулаг 4-24-46
107. Гүнсэnnоров Анхтуяа	Цагаанчулуут 19-3
108. Пүрэвдорж Борцэцэг	Цагаанчулуут 31-9
109. Эс-Олдох Мөнгөнзул	Цагаанчулуут 36-5
110. Ринчин Наранцэцэг	Цагаанчулуут 22-10
111. Бумцэнд Одонхүү	Цагаанчулуут 13-1
112. Батаахүү Оюунтунгалаг	Цагаанчулуут 35-4
113. Наянбуу Пүрэвжаргал	Цагаанчулуут 36-6
114. Баасанхүү Цэрэнноров	Цагаанчулуут 34-3
115. Лхагвасүрэн Энхцэцэг	Цагаанчулуут 28-12
116. Цэеэрэгзэн Байгальмаа	Шанд 34-02

117. Хандаа Буянзаяа	Шанд 18а-01
118. Цэгмэд Дэжидмаа	Шанд 65-01
119. Жаргал Мөнгөнчавхдас	Малчин 16-р баг
120. Бийжээ Нарангэрэл	Шанд 52б-04
121. Цэндхүү Отгончимэг	Шанд 7-13
122. Данзан Оюун	Шанд 32-02
123. Төмөрбаатар Оюун	Шанд 9-10
124. Хөхөө Оюунханд	Шанд 60-б-04
125. Гомбосүрэн Оюун-Эрдэнэ	Шанд 9-22
126. Гэлэгням Өсөхбаяр	Шанд 20-25
127. Самбуу Сарангэрэл	Шанд 23-23
128. Сэдбазар Саранчимэг	Шанд 71-14
129. Ганбаатар Цолмон	Шанд 69-10
130. Намдаг Цэцгээ	Шанд 9-14
131. Чулуунбаатар Алтантуяа	Эрдэнэ 22-а-8
132. Равдмаа Байгаль	Эрдэнэ 10-15
133. Баатар Даариймаа	Эрдэнэ 5-б-3
134. Дагва Жавзандолгор	Эрдэнэ 13-а-32
135. Дорлигжав Маандарий	Эрдэнэ 8-б-2
136. Сэрээтэрлхам Мягмармаа	Эрдэнэ 7а-8
137. Пүрвээ Мөнгөнцэцэг	Эрдэнэ 4-12
138. Монхоорой Нямхорлоо	Эрдэнэ 26а-7
139. Жаншин Наранцэцэг	Эрдэнэ 25а-2
140. Жигжид Оюунбилэг	Эрдэнэ 11-9
141. Аюурзана Сэлэнгэ	Эрдэнэ 40-б-1
142. Гэндэндарам Уранчимэг	Эрдэнэ 6-а-1
143. Жадамба Цэнгэлмаа	Эрдэнэ 8-13
144. Бат-Аюуш Чанцал	Эрдэнэ 29-а
145. Эрдэнэ Энхтуяа	Эрдэнэ 4-б-6
146. Баяраа Энх-Амгалан	Эрдэнэ 23-10



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 43

Эрдэнэт

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 25 дугаар зүйлийн 25.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3 дугаар заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга нарын ажлыг сар бүр дүгнэж, үнэлгээг үндэслэн, урамшуулал олгох журмыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Журмын дагуу багийн Иргэдийн нийтийн хурлын дарга нарын ажлыг дүгнэж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд улирал бүр танилцуулан шийдвэрлүүлэхийг хурлын Нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /3.Эрдэнээ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2013 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн
хуралдааны 43-р тогтоолын хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРЛЫН ДАРГА НАРТ УРАМШУУЛАЛ ОЛГОХОД МӨРДӨХ ЖУРАМ

Зорилго: Багийн нутаг дэвсгэрт хуулинд заагдсан бүрэн эрхээ хэрэгжүүлэх, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх, иргэдийн оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын үр дүнг сайжруулах, ИНХ-ын үйл ажиллагааг тогтмолжуулах

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 БИНХ-ын дарга, Тэргүүлэгчдийн хийж гүйцэтгэсэн ажлын тайланг сар бүрийн 25-ны дотор хурлын ажлын албанд ирүүлнэ.
- 1.2 Хурлын ажлын алба тогтоосон үзүүлэлтээр ажлыг дүгнэнэ.
- 1.3 БИНХ-ын дарга нарын ажлын үнэлгээг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна.

ХОЁР. БИНХ-ын дарга нарын ажлыг дүгнэх үзүүлэлт

- 2.1 БИНХ-ын Тэргүүлэгчдийн хийх ажлын төлөвлөгөө гүйцэтгэл, Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, үр дүн;
- 2.2 Аймаг, сумын ИТХ-аас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн ажил, биелэлт, нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэр, хэрэгжилт;
- 2.3 Хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, мэдээлэх хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, багийн Иргэний танхимын үйлчилгээг тогтмолжуулсан байдал;
- 2.4 Багийн нутаг дэвсгэрийн иргэд, ААН байгууллага, иргэний нийгмийн болон ТББ-ууд, орон тооны бус зөвлөлүүдийн ажилд чиглэл, үнэлэлт дүгнэлт өгсөн, хамтарч ажиллах талаар хийсэн ажил;
- 2.5 Багийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэлэлцүүлэх, эрэмбэлэх, гүйцэтгэлд хяналт тавихад иргэдийг оролцуулсан байдал;

2.6 Багийн Засаг дарга, ажлын албаны ажилтнууд, хэсгийн ахлагч нарыг ажлын удирлагаар хангаж, хамтарч ажиллах талаар хийсэн ажил;

2.7 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт шалгалт хийсэн ажлын үр дүн;

2.8 Иргэний журамт болон үндсэн үүргийн биелэлтийг хангуулах талаар авсан арга хэмжээ;

2.9 Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэж хариу өгсөн эсэх, БИНХ-ын тэмдэглэл, тогтоол, дотоод бичиг баримтын бүрдэлт;

2.10 Багийн ИНХ-ыг зохион байгуулсан багийн Засаг дарга, Өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсгийн /бусад/ ажлын тайланг хэлэлцүүлэн үнэлэлт дүгнэлт өгсөн, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын үр дүн;

ГУРАВ. Ажил дүгнэх

3.1 БИНХ-ын даргын ирүүлсэн ажлын тайлан, үр дүн, иргэдийн саналыг харгалзан сар бүр **10** хүртэл оноог өгнө.

3.2 Үнэлгээгээр нийт авах онооны

90%-с дээш үнэлгээ авсан БИНХ-ын даргын сарын урамшууллыг 100%,

70-90 % хүртэл үнэлгээ авсан БИНХ-ын даргын сарын урамшууллыг 80%,

50-70% дээш үнэлгээ авсан БИНХ-ын даргын сарын урамшууллыг 70%

хүртэл тооцон олгоно.

3.3 Үнэлгээгээр нийт авах онооны 50%-с доош үнэлгээ авсан БИНХ-ын даргын урамшууллыг тухайн сард хасах ба 3-аас дээш сар хангалтгүй үнэлгээ авсан БИНХ-д ИНХ-ын даргыг СИТХ чөлөөлөх санал оруулна.

3.4 Багийн ИНХ-ын дарга нарын ажлын үнэлгээгээр улиралд 1 удаа Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн, тогтмол сайн ажилласан БИНХ-ын даргыг хагас, бүтэн жилээр **30000 төгрөг** хүртэл төгрөгөөр шагнаж урамшуулна.

СУМЫН ИТХ-ЫН АЖЛЫН АЛБА



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 44

Эрдэнэт

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, 25 дугаар зүйлийн 25.1, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 дугаар заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын хэмжээнд дагаж мөрдөх Орон нутгийн хөгжлийн сангийн журам, Сумын дүрэм, Нийтийн зар түгээх журам, Иргэдийн нийтийн хурлын дэгийн журам, Төсвийн мэдээллийн ил тод байдлын журам, Иргэдийн санаачлагаар санал хураалт явуулах журмын төслийг боловсруулах, иргэдээр хэлэлцүүлэх, хуралдаанаар батлуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Холбогдох хууль, бодлого, стратегийн баримт бичгүүдийг удирдлага болгон, сумын онцлогт тохируулан, дээрх журмуудыг боловсруулж ажлын хэсэг ирүүлэхийг сумын Засаг даргын тамгийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Ч.Эрдэнэчимэг/-т, иргэд, сумын хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахыг ажлын хэсэгт тус тус даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 45

Эрдэнэт

Шагнуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.20 дахь заалт, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дор дурдсан эхийг “Алдарт эх II одон”-оор шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай. Үүнд:

Алдарт эхийн II одонгоор:

1. Гантулгын Түмэндэлгэр

Наран баг 38-07 тоот

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 15 өдөр

Дугаар 46

Эрдэнэт

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирлагын тухай хууль 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 3 дугаар бүлгийн 3.1.5 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зарцуулах дотоод журмын хэрэгжилт, сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих ажлын хэсгийн журмыг 1 дүгээр хавсралтаар, ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлэх ажил зохион байгуулж, Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж, төлөвлөгөөний биелэлт, тайланг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд улирал бүр танилцуулахыг Ажлын хэсгийн дарга /Б.Оюунбилэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04сарын 15 өдөр

Дугаар 47

Эрдэнэт

Шинээр баригдсан орон сууцанд
хаяг өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Оюут багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Оюут багийн нутаг дэвсгэрт шинээр баригдсан орон сууцны байрыг 2-40 А гэж хаяглахаар тогтоосугай.

2.Оюут багийн 2-40А орон сууцны байрын хаягжилт, иргэдийн хаягийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхийг сумын Засаг дарга /И.Баасанжав/, Оюут багийн Засаг дарга /О.Мөнх-Од/ нарт даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 48

Эрдэнэт

Шинээр баригдсан орон сууцанд
хаяг өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Дэнж багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Дэнж багийн нутаг дэвсгэрт шинээр баригдсан 40 айлын орон сууцны байрыг “Дэнж” -ийн 4, 5 дугаар байр гэж хаяглахаар тогтоосугай.

2.“Дэнж”-ийн 4, 5 дугаар орон сууцны байрын хаягжилт, оршин суугчдын хаягийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу хийж ажиллахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/, Дэнж багийн Засаг дарга /О.Наранбаяр/ нарт даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 49

Эрдэнэт

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дугаар зүйл, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай. Үүнд:

Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор:

- | | |
|-----------------|--|
| 1.Дашийн Лагваа | БОЭТ-д Мэс заслын тасгийн эрхлэгч,
зөвлөх эмч |
|-----------------|--|

Алтан гадас одонгоор:

- | | |
|----------------------------|------------------------|
| 1.Хасимын Авилхан | Өндөр настан |
| 2.Болдын Одончимэг | Өндөр настан |
| 3.Аюушийн Батсайхан | Өндөр настан |
| 4.Лувсангийн Түмэндэмбэрэл | Сумын ИТХ-ын Төлөөлөгч |

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

- | | |
|----------------------|--|
| 1. Гонгорын Булгамаа | ГХБХБХГ-ын Газрын төлбөр, үнэлгээ,
нэг цэгийн асуудал хариуцсан ажилтан |
|----------------------|--|

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04сарын 29 өдөр

Дугаар 50

Эрдэнэт

Говил, Оюут, Согоот, Цагаанчулуут, Булаг багийн
Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9.5 дахь заалт, Говил, Оюут, Согоот, Цагаанчулуут, Булаг багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Говил, Оюут, Согоот, Цагаанчулуут, Булаг багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс

- 1.С.Энхтайван
- 2.Ж.Эрдэнэбаатар
- 3.М.Амгалан
- 4.Б.Энхсансар
- 5.Ц.Эрдэнэчимэг
- 6.О.Галсмаа
- 7.С.Ариунаа
- 8.Сайннямбуу нарыг хассугай.

2. Говил, Оюут, Согоот, Цагаанчулуут, Булаг багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд

- 1.Б.Баттүвшин
- 2.Ц.Шугарсүрэн
- 3.П.Гантуяа
- 4.Ч.Ганзориг
- 5.С.Эрдэнэчимэг
- 6.Д.Нармандах
- 7.С.Өнөржаргал
- 8.Д.Оюундалай нарыг оруулсугай

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 51

Эрдэнэт

Сумын ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 3, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын ГХУСАЗСЗ-ийн бүрэлдэхүүнээс салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Наранцэцэгийг хассугай.

2.Зөвлөлийн Нарийн бичгийн даргаар 3.Эрдэнээг

Гишүүдэд Д.Ариунцэцэг /Сум дундын ерөнхий шүүгч/

Ж.Бямбажав /Туслах прокурор/

Б.Болд /Цагдаагийн газрын эрүүлжүүлэх баривчлах байрны дарга/

Б.Долгорсүрэн /Өмгөөлөгч/ нарыг баталсугай.

3.Зөвлөлийн гишүүдийн хариуцах ажлын чиглэл багуудын хуваарийг хавсралтаар баталсугай.

4.Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг зөвлөлийн нарийн бичгийн дарга /3.Эрдэнээ/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 52

Эрдэнэт

Данс нээлгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2; 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалтыг тус тус үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсугай.

2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хуваарилсан төсвийг төвлөрүүлэх төсвийн нэмэгдэл данс нээж өгөхийг Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэст уламжлахаар тогтоосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 53

Эрдэнэт

**Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн
хэсгийн хорооны байрлалд өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, Оюут, Баянцагаан, Эрдэнэ багийн Иргэдийн нийтийн хурлын тогтоол, Багийн Засаг даргын саналыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Оюут багийн 32 дугаар хэсгийн хороонд 40а байр, Мон турк сургуулийн дотуур байр

Баянцагаан багийн 33 дугаар хэсгийн хороонд Өнөр хотхон 1, 2 дугаар байр, Дулааны цахилгаан станц, шугам сүлжээ, Онцгой байдлын байр,

Эрдэнэ багийн 21 дүгээр хэсгийн хороонд хабитат 252, Туул 126 гудамж

Их залуу багийн 7 дугаар хэсгийн хороонд Толгод гэснийг хасаж, Яргуйтын 1-10-ийг 1-23 болгож тус тус нэмж 2013 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 19 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх хэсгийн хороодод шинэчилсэн хаягаар бүртгэгдсэн иргэдийг сонгогчдийн нэрсийн жагсаалтад оруулж, сонгуульд оролцох эрхийг хангаж ажиллахыг Улсын бүртгэлийн хэлтэс /Х.Цэцэгээ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 54

Эрдэнэт

**Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн
хэсгийн хорооны байрлалд өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, Оюут, Баянцагаан, Эрдэнэ багийн Иргэдийн нийтийн хурлын тогтоол, Багийн Засаг даргын саналыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Оюут багийн 32 дугаар хэсгийн хороонд 40а байр, Мон турк сургуулийн дотуур байр

Баянцагаан багийн 33 дугаар хэсгийн хороонд Өнөр хотхон 1, 2 дугаар байр, Дулааны цахилгаан станц, шугам сүлжээ

Эрдэнэ багийн 21 дүгээр хэсгийн хороонд хабитат 252, Туул 126 гудамжийг тус тус нэмж 2013 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 19 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх хэсгийн хороодод шинэчилсэн хаягаар бүртгэгдсэн иргэдийг сонгогчдийн нэрсийн жагсаалтад оруулж, сонгуульд оролцох эрхийг хангаж ажиллахыг Улсын бүртгэлийн хэлтэс /Х.Цэцэгээ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 55

Эрдэнэт

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дугаар зүйл, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай. Үүнд:

Урлагийн гавъяат зүтгэлтэн цолоор:

- | | |
|--------------------|--|
| 1.Отгоны Нацагдорж | “Ахмадын байгууллагын дэргэдэх
“Мөнгөн сор” хамтлагийн дарга,
найруулагч |
|--------------------|--|

Аж үйлдвэрийн гавъяат ажилтан цолоор:

- | | |
|------------------------|--------------|
| 1.Намхайдоржийн Энэбиш | Өндөр настан |
|------------------------|--------------|

Алтан гадас одонгоор:

- | | |
|--------------------------|------------------------|
| 1.Цэндийн Мягмар | Өндөр настан |
| 2.Жалцангийн Оюун | “Дерма” эмнэлэгийн эмч |
| 3.Лувсангийн Базар | Өндөр настан |
| 4.Шүхэрийн Алтанхүү | Өндөр настан |
| 5. Галсанжавын Сарантуяа | Өндөр настан |

6. Доохүүгийн Мөнхжаргал

Өндөр настан

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

1.Гэндэнжамцын Оюунцэцэг

Стандартчилал хэмжил зүйн
хэлтэсийн нягтлан бодогч

2.Балдандоржийн Гэрэл

Стандартчилал хэмжил зүйн
хэлтэсийн Түүхч-архивч

3.Доржийн Мягмар

Стандартчилал хэмжил зүйн
хэлтэсийн Агрохимич

4.Нямцэрэнгийн Сарантуяа

Стандартчилал хэмжил зүйн
хэлтэсийн цахилгааны инженер

5.Чойжилжавын Наранцэцэг

Бүсийн оношлогоо эмчилгээний
төвийн нягтлан бодогч, эдийн засагч

6.Жамъяны Должин

Бүсийн оношлогоо эмчилгээний
төвийн Сувилагч, Лаборант

7.Дагвын Алтанцэцэг

Өндөр настан

8.Загд-Очирын Соёлмаа

ҮЭ-ийн холбооны дэд дарга

9.Бямбаагийн Мягмарсүрэн

“Чандмань эрдэнэ” холбооны тэргүүн

10.Өсөхөөгийн Энхцогзол

“Эрдэнэт тисса” барилгын компаний
захирал

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 56

Эрдэнэт

**“Сумын 2013 оны төсөв батлах тухай” тогтоолын
хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Сумын 2013 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолын нэг, хоёрдугаар хавсралтын Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний жагсаалтын 1.1.3-т заасан “Ирээдүйн одод” сургуулийн спорт заалны барилгын дутуу ажлын гүйцэтгэлийн хөрөнгө оруулалт 100,000,000 /нэг зуун сая/ төгрөгийг нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, гэрэлтүүлэг, хаягжуулалтын төсөв гэж нэмэлт өөрчлөлт оруулсугай.

2. Сумын ИТХ-ын ээлжит III хуралдааны 2013 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Сумын 2013 оны төсөв батлах” 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 1.1.3, хоёрдугаар хавсралтын 1.1.3-аар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг өөрчлөлт, журмын дагуу зарцуулан гүйцэтгэлийг тайлагнахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-т даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 57

Эрдэнэт

Уурхайчин, Эрдэнэ багийн Амьжиргааг дэмжих
зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9.5 дахь заалт, Уурхайчин, Эрдэнэ багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Уурхайчин багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс С.Нямжав, Б.Булган нарыг чөлөөлж, Х.Цэцэгжаргал, Д.Алтанцэцэг нарыг томилсугай.

2.Эрдэнэ багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Т.Алтанцэцэг, А.Уранбор, Ж.Адъяа, С.Дүмбэн нарыг чөлөөлж, Г.Ганзаяа, Р.Мөнхжаргал, Т.Базардарга, С.Наранцэцэг, С.Давааням нарыг тус тус томилсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 58

Эрдэнэт

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дугаар зүйл, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ нь:**

1.Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай.

Үүнд:

Монгол улсын гавъяат багш цолоор:

1.Дэндэвийн Нарантуяа

Наран цогцолбор сургуулийн бага ангийн
багш

Алтан гадас одонгоор:

1. Авирмэдийн Намжилсүрэн

Өндөр настан

2. Цамбын Аюурзана

Өндөр настан

3. Пунцагийн Оролмаа

Өндөр настан

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

1. Магсаржавын Должинсүрэн	Баян-Өндөр цогцолбор сургуулийн хөгжмийн багш
2. Төмөрийн Цэндхүү	19-р цэцэрлэгийн эрхлэгч
3. Чүлтэмийн Ичинхорлоо	7-р цэцэрлэгийн эрхлэгч
4. Дагдангийн Уртнасан	2-р сургуулийн сургалтын менежер
5. Содномдоржийн Долгорсүрэн	Баян-Өндөр цогцолбор сургуулийн бага ангийн багш
6. Равдангийн Бадамханд	9-р цэцэрлэгийн хөгжмийн багш
7. Цэвээний Хүрэлтөмөр	ЭБЦТС ТӨХК-ийн засварын монтёр
8. Намсрайжавын Пүрэвдорж	ЭБЦТС ТӨХК-ийн засварын хэсгийн монтёр
9. Цэнд-Аюушийн Цагаанцоож	ЭБЦТС ТӨХК-ийн шуурхай үйлчилгээний монтёр
10. Шагдарсүрэнгийн Цолмон	БОАЖГ-ын бичиг хэргийн эрхлэгч, архивч
11. Баатарын Уламбаяр	Өндөр настан

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 59

Эрдэнэт

Тогтоолд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний жагсаалтын 1.1.3 дахь заалтад 56 дугаар тогтоолоор нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, гэрэлтүүлэг, хаягжуулалтын төсөв 100.000.000 /нэг зуун сая/ төгрөг зарцуулахаар өөрчлөлт оруулсныг хавсралт 1.1.3-т хаяг рекламьг крилл монгол үсэгтэй болгох төсөв 50.000.000 /тавин сая/ төгрөг, 1.1.7-д мэдээллийн самбарын LED гэрлэн чимэглэл хийх төсөв 50.000.000 /тавин сая/ төгрөг зарцуулахаар тус тус тогтоосугай.

2.Орон сууцны хорооллын байр хооронд амралт чөлөөт цагийн ногоон байгууламж бүхий иж бүрэн талбай тохижуулах төсвөөс хэмнэгдсэн 106.000.000 /Нэг зуун зургаан сая/ төгрөгийг 1.1.8, 1.1.9, 1.1.10-т заасан хөтөлбөр төслийг хэрэгжүүлэхээр баталсугай.

3.Сумын 2013 оны төсөв батлах тухай 03 дугаар тогтоолд оруулсан өөрчлөлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр батлагдсан ажлыг гүйцэтгэн сумын хурлын хуралдаанд тайлагнахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-т даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 60

Эрдэнэт

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дугаар зүйл, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ нь:**

1.Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай.

Үүнд:

Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор:

- | | |
|----------------------|---------------------------------|
| 1.Осорын Ганбаатар | ЭДЦС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал |
| 2.Лувсандамбын Одхүү | Хамгаалалтын албаны дарга |

Алтан гадас одонгоор:

- | | |
|-----------------------------|-------------------------|
| 1. Дарьсүрэнгийн Санж-Ёндон | Өндөр настан |
| 2. Олонбаярын Ложоо | Өндөр настан |
| 3. Бугын Батмөнх | ЭДЦС ТӨХК-ийн токарьчин |

4. Пүрэвжавын Даринчулуун

ХААЖДҮГ ариун цэврийн шинжлэгч
эмч

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

1.Загдын Баямбажав

Өндөр настан

2.Дэндэвийн Тойв

Группд, хувиараа

3.Галаагийн Сугар

ЭДЦС ТӨХК-ийн Цахилгаан дулааны
хянах хэмжүүр автоматикийн цехийн
дарга

4.Цэдэнгийн Чулуунхүү

ЭДЦС ТӨХК-ийн вагон буулгагч
бульдозерчин

5.Равжаагийн Баяраа

ЭДЦС ТӨХК-ийн зуухны тоноглолын
засварчин

6.Баатархүүгийн Майдармаа

Гаалийн газрын ГУБ, ГУАБ

7. Буянхишигийн Нандинцэцэг

Гаалийн газрын ГУБ

8. Дагвадоржийн Нямдаваа

Гаалийн газрын жолооч

9.Луузангийн Цэцэгмаа

ХААЖДҮГ малын ерөнхий эмч,
лабораторын эрхлэгч

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 61

Эрдэнэт

**СИТХ-ын ээлжит V хуралдаан зарлан
хуралдуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4, 64 дүгээр зүйлийг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ нь:**

НЭГ. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит V хуралдааныг 2013 оны 06 дугаар сарын 28-ны өдөр зарлан хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

Үүнд:

1.1. Сумын ИТХ-ын 6 дахь удаагийн сонгуулийн бүрэн архийн хугацаанд хийх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай

1.2. Орчны эрүүл ахуй ариун цэврийг сайжруулах, нохой муур устгах тухай

1.3. Сум хөгжүүлэх сангийн зарцуулалтын тухай

1.4. Сумын ОНХСангаар хийгдэх хөтөлбөр төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулах тухай

1.5. Бусад асуудал

ХОЁР. Хуралдааны бэлтгэл ажлын төлөвлөгөөг I хавсралтаар баталсугай.

ГУРАВ. Хуралдаанаар хэлэцүүлэх асуудлыг бэлтгэж 6 сарын 25-ны дотор Тэргүүлэгчдэд танилцуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-т даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 62

Эрдэнэт

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дугаар зүйл, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай.

Үүнд:

Эрчим хүчний гавъяат ажилтан цолоор:

1. Шагдарын Сүрэнжав	Өндөр настан
----------------------	--------------

Цэргийн хүндэт медалиар:

1. Бүдрагчаагийн Бадамсэрээжид	Өндөр настан
--------------------------------	--------------

Алтан гадас одонгоор:

1.Гомбын Нямрагчаа	Тэтгэвэрт
2.Дамдинжавын Санжхүү	Тэтгэвэрт
3.Очирбатын Лхагвасүрэн	Тэтгэвэрт
4.Чойжоохүүгийн Амаржаргал	Радио телевизийн сүлжээ УТҮГ-ын инженер

5.Жанцандоржийн Батсайхан	Орхон аймгийн Улсын нөөцийн салбарын харуул
6.Чимэдрэгзэнгийн Алтангэрэл	Өндөр настан
7.Рэнчиндоржийн Наранцэцэг	Өндөр настан
8. Цэвэгийн Бадрах	Өндөр настан
9. Мятагийн Мягмар	Өндөр настан
10. Лхагвын Ванчин	Өндөр настан
11.Дугарын Хүрэлдорж	Өндөр настан

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

1.Ложоогийн Хүрэлбат	Тэтгэвэрт
2.Билгээгийн Мөнхгэрэл	Тэтгэвэрт
3.Баастын Сүхбаатар	Тэтгэвэрт
4.Ванчигийн Түвшинбат	Тэтгэвэрт
5.Цэдэндоржийн Хандсүрэн	Тэтгэвэрт
	“Уурхайчин” үйлдвэрчний эвлэлийн холбооны тэргүүн
6.Сангарагчаагийн Ганбаатар	Тэтгэвэрт
7.Бат-Очирын Хишигээ	Тэтгэвэрт
8.Базарвааний Баярсайхан	Эрдэнэт цогцолбор сургуулийн биеийн тамирын багш
9.Мантааны Оюунцэцэг	ЭБЦТС ТӨХК-ийн Цахилгааны байцаагч
10.Шаравын Үүрийнтуяа	Техник хяналт, сургалтын инженер
11.Цэдэнгийн Маруш	Өндөр настан
12.Намчингийн Пүрвээ	Өндөр настан
13.Дэжидийн Дархижав	Өндөр настан
14.Дагвын Батчулуун	Өндөр настан

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 63

Эрдэнэт

**Үндэсний баяр наадмын төсөв
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 271 дүгээр тогтоолыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Ардын хувьсгалын 92 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний зардлыг 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний жагсаалтын 1.1.5-аар батлагдсан орон сууцны хорооллын байр хооронд 8 га газарт амралт чөлөөт цагийн ногоон байгууламж бүхий иж бүрэн талбай байгуулж тохижуулах 943,838,000 /есөн зуун дөчин гурван сая нэг зуун гучин найман мянган/ төгрөгийн төсвийн хэмнэлтийн зардлаас хасаж 5 000 000 /таван сая/ төгрөгийг зарцуулахаар тодотгосугай.

2. Баяр наадмын арга хэмжээний зардлын төсвийн хувиарын нэр төрлийг хавсралт 1-ээр баталсугай.

3. Баяр наадмын зардлын төсөв нийт 5 000 000 /Таван сая/ төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас хуулийн дагуу зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 64

Эрдэнэт

**СИТХ-ын ээлжит V хуралдааны
товыг хойшлуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит V хуралдааныг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 65

Эрдэнэт

**Багийн ИНХ хуралдуулах тов
тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, Захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 14 тоот шийдвэрийг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1.Наран багийн ИНХ-ын дарга, багийн Засаг дарга сонгох ИНХ-ыг хүчингүйд тооцсон тул дахин сонгууль явуулах багийн ИНХ-ын хуралдааныг “Наран” цогцолбор сургуулийн биеийн тамирын зааланд 2013 оны 07 дугаар сарын 31-ний дотор зарлан хуралдуулахаар тогтоосугай.

2.Наран багийн ИНХ-ыг зохион байгуулах байр бусад бэлтгэл ажлыг ханган хуулийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг Сумын Засаг дарга /И.Баасанжав/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 66

Эрдэнэт

Хүндэт тэмдэгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1 дэх заалт, “Хүндэт тэмдэг”-ээр шагнах тухай Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2010 оны 3 дугаар тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Ардын хувьсгалын 92 жилийн ойг тохиолдуулан, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан дараах хүмүүсийг Баян-Өндөр сумын “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

1. Чулуунбатын Уламбаяр	АМЭА-ийн тэргүүн
2. Гүндийн Лхагва	Хүндэт донор
3. Баатарчулууны Нямдаваа	Дэлхийн зөнгийн ажилтан
4. Гунгаасамбуугийн Нарантуяа	ИГХХМН-ийн Олон нийтийн байцаагч
5. Володъяа Уранболор	Энэрэл төвийн нийгмийн ажилтан
6. Лхамсүрэнгийн Болдмаа	Зэст багийн хэсгийн ахлагч
7. Аварзэдийн Баясгалан	Рашаант багийн хэсгийн ахлагч
8. О.Гүлгина	Өндөр настан
9. Шохайн Кулашай	Өндөр настан
10.Ү.Хундыз	Өндөр настан

11.Кокейн Демон	Өндөр настан
12.Бурысын Сайланхан	Өндөр настан
13.Рахатбайн Кулыза	Өндөр настан
14.Нямаагийн Алтанцэцэг	Эрдэнэт бест массажийн төв
15.Ондоохүүгийн Отгонбат	Эрдэнэт бест массажийн төв
16.Лхагвамядагийн Отгонтэнгэр	5-р цэцэрлэгийн багш
17.Жамъяндоржийн Даариймаа	18-р цэцэрлэгийн багш
19.Дугаржавын Дэлгэрмаа	8-р сургуулийн багш
20.Доржийн Норовсүрэн	Улсын нөөцийн салбарын харуул
21.Хундагын Цэрэндаш	Онцгой байдлын газрын багийн мастер
22.Пүрэвийн Үзмээ	ЭДЦС ТӨХК-ийн хэмжүүрийн инженер
23.Дэлгэрийн Жавзандулам	Өндөр настан
24.Бадрахын Нямжав	Өндөр настан
25.Бат-Өлзийн Цэгмэд	Өндөр настан
26.Бүдийн Дулмаа	Өндөр настан
27.Ядамжавын Тунгалаг	Өндөр настан
28.Лолёогийн Хоролсүрэн	Өндөр настан
29.Дондовын Жавзан	Өндөр настан
30.Лувсангийн Цэрэннадмид	Өндөр настан
31.Цэрэнпилийн Бадам	Өндөр настан
32.Бямбажавын Замбагацэцэг	Өндөр настан
33.Нацагийн Чимэд	Өндөр настан

2.Хүндэт тэмдэгээр шагнагдсан нэр бүхий хүмүүст дагалдах мөнгөн шагнал 30 000 /Гучин мянган/ төгрөг олгохыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 67

Эрдэнэт

**Багийн ИНХ хуралдуулах тов
тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, Захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 14 тоот шийдвэрийг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1.Наран багийн ИНХ-ын дарга, багийн Засаг дарга сонгох ИНХ-ыг хүчингүйд тооцсон тул дахин сонгууль явуулах багийн ИНХ-ын хуралдааны товыг хавсралтаар баталсугай.

2.Наран багийн ИНХ-ыг зохион байгуулах байр бусад бэлтгэл ажлыг ханган хуулийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг Сумын Засаг дарга /И.Баасанжав/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 68

Эрдэнэт хот

**Шинээр баригдсан орон сууцны байруудад
хаяг өгөх тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, Бүрэнбүст багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Бүрэнбүст багийн нутаг дэвсгэрт шинээр баригдсан орон сууцны байрыг “Залуус хотхон” 1, 2, 3, 4 дүгээр байр гэж хаяглахаар тогтоосугай.

2. “Залуус хотхон” 1, 2, 3, 4 дүгээр байрын хаягжилт, иргэдийн хаягийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхийг Сумын Засаг дарга /И.Баасанжав/, Бүрэнбүст багийн Засаг дарга /Ц.Энхтөр/ нарт даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 69

Эрдэнэт

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дугаар зүйл, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай.

Үүнд:

Монгол улсын Хөдөлмөрийн баатар цолоор:

- | | |
|-------------------|--|
| 1.Хаваны Байгавил | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн
Баяжуулах фабрикийн Хэсгийн дарга |
|-------------------|--|

Монгол улсын Аж үйлдвэрийн гавъяат ажилтан цолоор:

- | | |
|--------------------|---|
| 1.Тогтохын Санах | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ЗМЗ-д
цахилгаан хийн гагнуурчин |
| 2.Лхайезамын Батаа | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн
Технологийн сургуулийн захирлын
мэргэжлийн сургалт хариуцсан орлогч |

- | | |
|----------------------------|--|
| 3.Равдандоржийн Жанчивдорж | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Авто тээврийн байгуулалгад хэсгийн дарга |
| 4.Чүлтэмийн Нямдалай | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Эрчим хүчний цехийн тоног төхөөрөмжийн засварчин |

Монгол улсын Гавъяат уурхайчин цолоор:

- | | |
|---------------------|--|
| 1.Дамдинжавын Даваа | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн автогрейдерчин |
|---------------------|--|

Монгол улсын гавъяат тамирчин цолоор:

- | | |
|------------------------|--|
| 1.Чойжгаваагийн Тэрбиш | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ЧХХ-ийн Техник хяналтын албаны чанар шалгагч |
|------------------------|--|

Монгол улсын Гавъяат барилгачин цолоор:

- | | |
|-------------------------|--|
| 1.Дашзэвэгийн Дашдэлгэр | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Барилга засварын цехийн Бригадын дарга |
|-------------------------|--|

Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор:

- | | |
|-----------------------|--|
| 1.Доедын Чадраабал | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Авто тээврийн байгууллагын хэсгийн дарга |
| 2.Самдангийн Мөнхтэгш | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Төмөр замын цехийн дарга |
| 3.Лхагвын Ичинлхам | Эрдэнэт өртөөний жижүүр |

Алтан гадас одонгоор:

1.Рэнчинхоролын Ядмаа	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Баяжуулах fabriкийн тоног төхөөрөмжийн засварчин
2.Содномцэрэнгийн Бат-Эрдэнэ	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Баяжуулах fabriкийн БТХ-т орлогч дарга
3.Мижиддоржийн Доржжүгдэр	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Баяжуулах fabriкийн бутлуурчин
4.Бадамгаравын Эрдэнэчимэг	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Баяжуулах fabriкийн краны машинч
5.Гочоогийн Борбаатар	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Баяжуулах fabriкийн токарьчин
6.Чулуунсүрэнгийн Хулбаатар	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Баяжуулах fabriкийн ээлжийн мастер
7.Ломбын Дашсамбуу	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Баяжуулах fabriкийн тоног төхөөрөмжийн засварчин
8.Баасан Лхагвасүрэн	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Баяжуулах fabriкийн краны машинч
9.Манлайн Дамба	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ЗМЗ-д технологийн товчооны дарга
10.Дашням Саруул	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ЗМЗ-д гүүрэн краны машинч
11.Батаагийн Сүхбат	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ЗМЗ-д тоног төхөөрөмжийн засварчин
12.Лувсан сүхбаатар	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ХАБЭА-н хэлтэсийн мониторингийн инженер

13.Госбосүрэнгийн Даваацэрэн	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Авто тээврийн байгууллагад белазын жолооч
14.Бямбараашийн Өлзийсайхан	Тэтгэвэрт
15.Лувсандампилын Ганбат	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ГРП-ийн өрөмдөгч
16.Наранхүүгийн Хандсүрэн	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ЧХХ-ийн Лабораториудын чанар ба аргачлалын менежер
17.Балжиннямын Оюунгэрэл	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ЧХХ-ийн хэмжил зүйч инженер
18.Самранзын Халтар	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ЧХХ-ийн чанар шалгагч
19.Лэгцэгийн Ганхуяг	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Худалдааны хэлтэсийн орлогч дарга
20.Долгорсүрэнгийн Эрдэнэцогт	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хөгжлийн хэлтэсийн Баяжуулагч инженер
21.Цэнд-Аюушийн Дашдорж	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Төмөр замын цехийн Илчит тэрэгний машинч
22.Нямсүрэнгийн Алтанчимэг	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Захиргаа аж ахуйн цехийн мастер
23.Баасанхүүгийн Мягмаржав	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Насосны машинч
24.Гомбожавын Гиваапил	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Орон сууцны цехийн Сантехникийн засварчин

25.Сосорбарамын Гансүх	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Эрчим хүчний цехийн Ус хангамжийн хэлтэсийн цахилгаанчин
26.Бат-Очирын Алтанхишиг	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Инженерийн зураг төслийн хэлтэсийн төсвийн инженер
27.Базаржавын Цогтбаатар	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн харъяа РСЦ ХХК-ийн өрлөгчин
28.Дамбадаржаагийн Уламбаатар	“Эрдэнэт үйлдвэр” харъяа ХХК-ийн РСЦ ХХК-ийн Хангамжийн инженер
29.Доржготовын Зориг	Орхон аймгийн Татварын хэлтэсийн Улсын ахлах байцаагч
30.Доржжавын Билэгт	“10+11” СӨХ-ны захирал
31.Хаянхярваагийн Юндэндорж	Тэтгэвэрт

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

1.Пүрэвдагвын Эрдэнэ	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хүдрийн ил уурхайн уулын тоног төхөөрөмжийн засварын слесарь
2.Элдэвийн Цэмбэлжав	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хүдрийн ил уурхайн Экскаваторын машинч
3.Жанчивын Чулуунхүү	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хүдрийн ил уурхайн Экскаваторын машинч
4.Дондогийн Цэцэнхүү	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Хүдрийн ил уурхайн Цахилгаан ба хийн гагнуурчин

5.Доржийн Бямбасүх	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн БФ-ийн Шүүн хатаах хэсгийн Тоног төхөөрөмжийн засварчин
6.Цэндийн Баяртай	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн БФ-ийн ээлжийн дарга
7.Бүлээхэний Баасанжав	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн БФ-ийн Баяжуулагч
8.Олчоогийн Билэгсайхан	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн БФ-ийн Тээрмийн машинч
9.Дашгиагийн Цэнджав	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн БФ-ийн Урвалжийн хэсэгт Мастер
10.Дугаржавын Мэндбаяр	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Авто тээврийн байгууллагын Автобусны жолооч
11.Бисолтаны Авиддолдой	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Авто тээврийн байгууллагын Засварын мастер
12.Навиханы Тамей	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Авто тээврийн байгууллагын жолооч
13.Лочингийн Жаргалсайхан	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Авто тээврийн байгууллагын жолооч
14.Норовсамбуугийн Батхуяг	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Авто тээврийн байгууллагын Белазын засварчин
15.Ваанчигийн Довчинбаатар	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Авто тээврийн байгууллагын Хүнд даацын белазын засварчин

16.Шаравдоржийн Наранбаатар	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Цахилгаан цехийн дарга
17.Цэгмэдийн Баярсайхан	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Цахилгаан цехийн цахилгаанчин
18.Дашпунцагийн Лхагва	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Цахилгаан цехийн цахилгаанчин
19.Гончигийн Баатарсүрэн	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ГРП-ийн Инженер геологич
20.Готовын Пүрэвдорж	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Засвар угсралтын цехийн Тоног төхөөрөмжийн засварчин
21.Цэдэнгийн Титов	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Засвар угсралтын цехийн цахилгаанчин
22.Содномдоогийн Бямбачулуун	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Засвар угсралтын цехийн Мастер
23.Чойжинжавын Тайванхүү	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Захиргаа аж ахуйн цехийн угаалгын машины оператор
24.Адилбишийн Нэргүй	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий Эрчим хүчний хэлтсийн Төлөвлөлт тооцоо хариуцсан инженер
25.Бямбаагийн Баттайван	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захиргаа, ХАБ, эрүүл ахуйн хэлтэсийн ХАБ-ын дарга
26.Халтарын Амарсанаа	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Дулааны станцын Үнс зайлуулах төхөөрөмжийн машинч

27.Санжийн Батмөнх	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Холбоо мэдээллийн технологи ба автоматжуулалтын цехийн цацраг хэмжигч лаборант
28.Хуушааны Ганбат	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Холбоо мэдээллийн технологи ба автоматжуулалтын цехийн цахилгаанчин
29.Алтангэрэлийн Тунгалаг	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Шинжилгээний төв лабораторийн Баяжуулагч
30.Ням-Осорын Одмаа	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Шинжилгээний төв лабораторийн Хүний нөөцийн менежер
31.Цэнджавын Энхтуяа	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Спорт цогцолборын Лаборант
32.Пунцагийн Лхагваа	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Технологийн сургуулийн Захирлын туслах, хичээлийн зохицуулагч
33.Дүгэржавын Бурмаа	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Орон сууцны цехийн Аж ахуйн эрхлэгч
34.Балдуузын Паламдорж	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Материал Техникийн хангамжийн баазын авто ачигчийн жолооч
35.Шагдарсүрэнгийн Энхцогт	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Эрчим хүчний цехийн Нарийн хэмжүүр автоматикийн угсралт тохируулгын инженер

36.Лувсангомбын Хишигсүрэн	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Эрчим хүчний цехийн засварчин, насосны машинч
37.Осордэлэгийн Энхбат	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Эрчим хүчний цехийн Ерөнхий эрчим зүйч
38.Цэрэндэлэгийн Цэгмид	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Инженерийн зураг төслийн хэлтэсийн барилгын товчооны тэргүүлэх мэргэжилтэн
39.Маналжавын Пүрэвсүрэн	“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн харъяа РСЦ ХХК-ийн Засал чимэглэлчин, хэсгийн дарга
40.Нацагийн Мөнхцэцэг	“Эрдмийт” ХХК-ний Махны үйлдвэрт Мал эмнэлэг-Ариун цэврийн албаны дарга
41.Сономпунцагийн Туул	Орхон аймгийн Татварын хэлтэсийн Улсын байцаагч
42.Бүдрагчаагийн Лхамсүрэн	Орхон аймгийн Татварын хэлтэсийн Улсын байцаагч
43.Бадамжавын Эрдэнэбулган	БОЭТ-ийн Төрөх тасгийн эрхлэгч
44.Нямандорж Цэцэгээ	БОЭТ-ийн Зүрх судасны эмч
45.Гончигийн Оюун-Эрдэнэ	БОЭТ-ийн Мэдрэлийн тасгийн ахлах сувилагч
46.Мөнхөөгийн Батдэлгэр	БОЭТ-ийн Халдвартын тасгийн сувилагч
47.Санжаагийн Тунгалаг	БОЭТ-ийн ДОХ, БЗДХ-ын кабинетийн сувилагч

48.Лувсанзундуйгийн Наранхүү	БОЭТ-ийн НСЭ-ний Биеийн тамирын бага эмч
49.Бямбаагийн Батзориг	“Монгема” ХХК-ийн Махны үйлдвэрийн мал эмнэлгийн албаны дарга
50.Жамсрангийн Санжаа	Тэтгэвэрт
52.Чоёнгийн Саранцэцэг	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны ахлах нягтлан бодогч
53.Баттулгын Чинзориг	“Золотой мастер” өрмийн компанид гагнуурчин /ХБИ/

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 71/а

Эрдэнэт хот

Тогтоолд нэмэлт өөрчлөлт

оруулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төсөв батлах тухай 03 дугаар тогтоолоор батлагдсан 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн ажлаас /Хавсралт I/ хэмнэгдсэн 215.631.895 /Хоёр зуун арван таван сая зургаан зуун гучин нэгэн мянга найман зуун ерэн таван/ төгрөгийг 5.564.559 /Таван сая таван зуун жаран дөрвөн мянга таван зуун тавин есөн/ төгрөгийг Малчин багт трансформатор шинээр сольж тавихад, 210.067,336 /Хоёр зуун арван сая жаран долоон мянга гурван зуун гучин зургаан/ төгрөгийг дээврийн засвар шинэчлэхэд зарцуулахаар тус тус тогтоосугай.

2. Малчин багт тарнсформатор шинээр сольж тавих төсвийг 1.1.12, дээврийн засвар шинэчлэх төсвийг 1.1.13-т заасан хөтөлбөр төслийг хэрэгжүүлэхээр /Хавсралт II/ баталсугай.

3. Сумын 2013 оны төсөв батлах тухай 03 дугаар тогтоолд оруулсан өөрчлөлтийн дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр батлагдсан ажлыг гүйцэтгэн сумын Хурлын хуралдаанд тайлагнахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2013 оны 07 дугаар сарын 17 -ны өдрийн
71 дугаар тогтоолын I хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2013 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨТӨЛБӨР, ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Хэрэгжүүлсэн төсөв	Хэмнэлт
1	Гэр хорооллын багуудын гудамж талбайн гэрэлтүүлэг хийх	200,000,000	179,122,787	20,878,213
2	Үерийн усанд эвдэгдсэн газар ус зайлуулах далан суваг сэргээн засварлах	50,000,000	50,000,000	
3	Ирээдүйн өдөд сургуулийн спорт залны барилгын дутуу ажлын гүйцэтгэл	100,000,000		
	Нийтийн эзэмшлийн хаяг рекламьг кирилл монгол болгох		50,000,000	
	Нийтийн эзэмшлийн самбар лед гэрэлтүүлэг		50,000,000	
4	Нийтийн аж ахуйн үйлчилгээний зориулалтаар гэр хорооллыг удны усаар хангах зөөврийн усны автомашин	84,000,000,	79,000,000	5,000,000
5	Орон сууцны байр хоорондын 8-аас доогшүй газарт амралт чөлөөт цагийн талбайтай ногоон байгууламж бүхий иж бүрэн тохижилт хийх	943,138,000	706,000,000	237,138,000
6	Бэлчээрийн усан хангамж бэлчээр нөхөн сэргээх хашиж хамгаалах малын эрүүл мэнд үржлийн арга хэмжээний зардал	50,000,000	50,000,000	
7	Орон сууцны дээвэр заадасны засвар	500,000,000	477,956,680	22,043,320
8	Сум багуудын ажлын байр цахилгаан гэмтэл галын дохиоллын засвар гадна тохижилт гэрэлтүүлэг	86,300,000	86,300,000	
9	Орон сууцны сантехник цахилгаан засвар	370,000,000	328,426,638	41,573,362
10	Зураг төсөв	260,000,000	260,000,000	
ДҮН		2,643,438,00	2,316,806,105	326,631,895

Хэмнэлтээс зарцуулсан төсөв				
1	Урт цагааны гудамжны нүүрний пасат засварлах		10,000,000	
2	Урт цагааны худалдааны гудамжны дээврийн засвар		76,000,000	
3	Хотын гудамж талбайн сандал		20,000,000	
4	Үндэсний баяр наадмын зардал		5,000,000	
ДҮН			111,000,000	
Хэмнэлтээс зарцуулах төсөв /тодотгох/				
1	Малчин багт трансформатор шинээр сольж тавих			5,564,559
2	Дээврийн засварт			210,067,336
ДҮН				215,631.895

Баян-Өндөр сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2013 оны 07 дугаар сарын 17 -ны өдрийн
71 дугаар тогтоолын II хавсралт

**ТӨСВИЙН ЭРХ ЗАХИРАГЧ НАРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХӨТӨЛБӨР, ХҮРЭХ ҮР ДҮН**

№	Төсвийн эрх захирагч нар, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр	Хүрэх үр дүн		Зарцуулах төсөв /сая төгрөг/
		Чанар	Тоо	
1.1.12	Малчин багийн трансформатор шинээр сольж тавих	Иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх	1	5.564.559
1.1.13	Дээврийн засварт	Иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх		210.067.336
НИЙТ				215.631.895

оОо



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 08 сарын 20 өдөр

Дугаар 71

Эрдэнэт хот

Баг хуваах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, Багийн ИНХ, Сумын Засаг даргын саналыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Шанд, Их залуу, Рашаант багийн хүн ам, өрхийн тоог харгалзан Даваат, Яргуйт, Уртын гол баг байгуулах саналыг дэмжсүгэй.

2. Шинээр байгуулах Даваат, Яргуйт, Уртын гол багт ажиллах ажиллагсдын цалин, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардлыг тооцоог хийж 2014 оны төсөвт суулган батлуулахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 72

Эрдэнэт хот

**Булаг, Дэнж багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт, Булаг, Дэнж багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Булаг багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Б.Оюунбаяр, Д.Цэрэнханд, Т.Пионер нарыг чөлөөлж, С.Ариунаа, Ч.Нарантуяа, Г.Цогт-Очир нарыг томилсугай.

2.Дэнж багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс М.Алтанмягмар, Б.Нэмэхбаяр нарыг чөлөөлж, даргаар Б.Соёлмаа, гишүүнээр Ө.Дэлгэрмаа, Л.Тэрбиш нарыг тус тус томилсугай.

3.Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийг хуулийн дагуу удирдлагаар хангаж ажиллахыг Сумын ЗДТГ-ын дарга /М.Эрдэнэчимэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 73

Эрдэнэт хот

**Бүрэнбүст, Уртбулаг багийн Амьжиргааг
дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт, Бүрэнбүст, Уртбулаг багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ нь:**

1.Бүрэнбүст багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Н.Сүхбаатар, Д.Догсмаа нарыг чөлөөлж, Б.Байгалмаа, П.Мөнхтуяа нарыг томилсугай.

2.Уртбулаг багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс И.Амгаланбаатар, Л.Анхбаяр, Б.Болормаа, Д.Жамъянмядаг нарыг чөлөөлж, даргаар Б.Батцэцэг, Д.Отгончимэг, Б.Нарангэрэл, А.Чинбат нарыг тус тус томилсугай.

3.Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийг хуулийн дагуу удирдлагаар хангаж ажиллахыг Сумын ЗДТГ-ын дарга /М.Эрдэнэчимэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 74

Эрдэнэт хот

**Хүрэнбулаг, Зэст багийн Амьжиргааг
дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт, Хүрэнбулаг, Зэст багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ нь:**

1.Хүрэнбулаг багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Б.Алтаншагайг 2013 оны 08 сарын 20-ны өдрөөс чөлөөлж, Б.Алтанцэцэгийг томилсугай.

2.Зэст багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Г.Даш-Өлзий, Б.Уранчимэг нарыг 2013 оны 08 сарын 20-ны өдрөөс чөлөөлж, Д.Баасанжав, Б.Саруул нарыг тус тус томилсугай.

3.Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийг хуулийн дагуу удирдлагаар хангаж ажиллахыг Сумын ЗДТГ-ын дарга /М.Эрдэнэчимэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 75

Эрдэнэт хот

**Их залуу, Цагаанчулуут багийн Амьжиргааг
дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт, Их залуу, Цагаанчулуут багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ нь:**

1.Их залуу багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Л.Мөнхтуяа, Г.Дуламжав, Л.Отгонжаргал, Л.Содбилэг, Л.Жамсран нарыг 2013 оны 08 сарын 20-ны өдрөөс чөлөөлж, Д.Жамъянмягдаг, Х.Алтангэрэл, Я.Чулуунбаатар, Т.Эрдэнэтуяа, Б.Батбаатар нарыг томилсугай.

2.Цагаанчулуут багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Б.Билэгсайханыг 2013 оны 08 сарын 20-ны өдрөөс чөлөөлж, Ж.Нандинзулыг томилсугай.

3.Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийг хуулийн дагуу удирдлагаар хангаж ажиллахыг Сумын ЗДТГ-ын дарга /М.Эрдэнэчимэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 76

Эрдэнэт хот

**Малчин, Шанд багийн Амьжиргааг
дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт, Малчин, Шанд багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Малчин багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Б.Баярсайхан, Г.Байгалмаа, Ц.Одгэрэл, Б.Золзаяа нарыг 2013 оны 08 сарын 20-ны өдрөөс чөлөөлж, даргаар Б.Алтаншагай, гишүүнээр Б.Энхээ, Ж.Жамбалравдан, Д.Мөнхдэлгэр нарыг томилсугай.

2.Шанд багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Г.Баярмагнай, С.Гиваасүрэн нарыг 2013 оны 08 сарын 20-ны өдрөөс чөлөөлж, Н.Ганганбат, Ж.Төгсбаяр нарыг томилсугай.

3.Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийг хуулийн дагуу удирдлагаар хангаж ажиллахыг Сумын ЗДТГ-ын дарга /М.Эрдэнэчимэг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 77

Эрдэнэт

**Согоот, Рашаант багийн Амьжиргааг
дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9.5 дахь заалт Малчин, Шанд багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Согоот багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Л.Самбуу, Г.Отгончимэг нарыг 2013 оны 08-р сарын 20-ны өдрөөс чөлөөлж, Э.Мөнхтуул, Л.Эрдэнэтуяа нарыг томилсугай.

2.Рашаант багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Жаргалсайхан, Ж.Лхагважаргал, Б.Цогзолмаа, А.Баясгалан, Хишигжаргал нарыг 2013 оны 08-р сарын 20-ны өдрөөс чөлөөлж, даргаар Ц.Мөнх-Эрдэнэ, гишүүнээр Л.Батцэцэг, Д.Түмэннаст, Л.Хөвсгөл, Ө.Мөнхжаргал нарыг тус тус томилсугай.

3.Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийг хуулийн дагуу удирдлагаар хангаж ажиллахыг Сумын ЗДТГ-ын дарга /М.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 78

Эрдэнэт

**Сумын “Хүндэт тэмдэг”-ээр
шагнах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Баян-Өндөр сумын “Хүндэт тэмдэг”-ээр тэргүүний хүмүүсийг шагнах журмыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сумын “Хүндэт тэмдэг”-ээр

- Равдангийн Сүрэнхүү – ЭДЦС ТӨХК-ийн засварчин
- Цэдэвийн Лхагвадорж - ЭДЦС ТӨХК-ийн засварчин
- Санжийн Лхамсүрэн - Их залуу багийн өндөр настан

нарын шагнасугай.

2. Нэр бүхий хүмүүст шагнал гардуулах ажлыг журмын дагуу зохион байгуулахыг хурлын нарийн бичиг /3.Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 79

Эрдэнэт

Шинээр баригдсан орон сууцанд
хаяг өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь заалт, хот байгуулалтын тухай хуулийн 10-р зүйлийн 10.1.6-р заалт, Бүрэнбүст багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Бүрэнбүст багийн нутаг дэвсгэрт шинээр баригдсан орон сууцны байрыг “Залуус хотхон” 22 дугаар байр гэж хаяглахаар өөрчилсүгэй.

2. “Залуус хотхон” 22 дугаар байрын хаягжилт, оршин суугчдын хаягийн хөдөлгөөнийг зохих журмын дагуу хийж ажиллахыг сумын Засаг дарга /И.Баасанжав/, Бүрэнбүст багийн Засаг дарга /Ц.Энхтөр/ нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 07-р сарын 17-ны өдрийн 68 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 80

Эрдэнэт

**Говил, Баянцагаан багийн Амьжиргааг
дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9.5 дахь заалт Говил, Баянцагаан багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Говил багийн Амьжиргаа дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Ц.Шугарсүрэнг 2013 оны 09-р сарын 17-ны өдрөөс чөлөөлж, Ж.Батцэцэгийг томилсугай.

2.Баянцагаан багийн Амьжиргаа дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Б.Баасансүрэн, Л.Цацралтмаа, Ж.Оюунтунгалаг, Х.Сүнжидмаа, Д.Эрдэнэбилэг, Д.Нямсүрэн нарыг 2013 оны 09-р сарын 17-ны өдрөөс чөлөөлж, даргаар Б.Баярсайхан, гишүүдээр Б.Батцэцэг, Б.Одончимэг, Б.Батбаян, Ш.Наранцэцэг, Х.Мөнхбаяр нарыг тус тус томилсугай.

3.Амжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийг хуулийн дагуу удирдлагаар хангаж ажиллахыг Сумын ЗДТГ-ын дарга /М.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 81

Эрдэнэт

Монгол улсын Төрийн дээд шагнал
одон, медалиар шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дугаар зүйл, Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журмыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ нь:**

1.Дор дурдсан хүмүүсийг Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар шийдвэрлэж, Аймгийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд уламжлахаар тогтоосугай.

Үүнд:

Монгол улсын Хөдөлмөрийн гавъяаны улаан түгийн одонгоор:

цолоор:

- | | |
|-----------------------|--|
| 1. Хөхийн Дагважанцан | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ахмадын нэгдсэн зөвлөлийн гишүүн |
| 2. Сүрэнгийн Лхаажав | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ахмадын нэгдсэн зөвлөлийн гишүүн |
| 3. Паалайгийн Маам | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ахмадын нэгдсэн зөвлөлийн гишүүн |
| 4. Довчингийн Даваа | “Олон онц” ХХК-ийн малын эмч |

Соёлын гавъяат зүтгэлтэн цолоор:

- | | |
|-------------------------|---------------------------------------|
| 1.Дүгэрийн Одончимэг | Уурхайчин соёлын ордны найруулагч |
| 2.Егүүзэрийн Баярмагнай | Хүүхэд залуучуудын театрын найруулагч |

Алтан гадас одонгоор:

- | | |
|------------------------------|--|
| 1. Гэндэндоржийн Хишигжаргал | |
| 2. Аварзэдийн Мижиддорж | Тэтгэвэрт |
| 3. Гомбосүрэнгийн Дамдин | Тэтгэвэрт |
| 4. Болдын Одончимэг | Тэтгэвэрт |
| 5. Тогтохын Ичинхорлоо | Тэтгэвэрт |
| 6. Галцогтын Жавзмаа | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ахмадын нэгдсэн зөвлөлийн гишүүн |
| 7. Лонровын Самбуу | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ахмадын нэгдсэн зөвлөлийн гишүүн |
| 8. Чадраавалын Пүрэвжав | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ахмадын нэгдсэн зөвлөлийн гишүүн |
| 9. Аюушийн Шийтэв | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ахмадын нэгдсэн зөвлөлийн гишүүн |
| 10. Чимгээгийн Цэнд-Аюуш | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ахмадын нэгдсэн зөвлөлийн гишүүн |
| 11. Ёндонгийн Цэрэнханд | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ахмадын нэгдсэн зөвлөлийн гишүүн |
| 12. Лхагвадоржийн Ганчимэг | Аймгийн музейн сан хөмрөгийн эрхлэгч |

- | | |
|------------------------------|---|
| 13. Дэмиддагвын Баярсайхан | Орхон аймаг дахь салбарын дарга |
| 14. Чүлтэмжамцын Лхагвасүрэн | “Бадар хундага-Рашаан” дотрын
эмнэлгийн их эмч |

Хөдөлмөрийн хүндэт медалиар:

- | | |
|----------------------------|---|
| 1. Жанчиврэнчингийн Хандаа | Тэтгэвэрт |
| 2. Жамсрангийн Осоржамаа | Тэтгэвэрт |
| 3. Норжмаагийн Цэрэндорж | “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ахмадын
нэгдсэн зөвлөлийн гишүүн |
| 4. Сугарын Ганзориг | “Бет-Андууд” ХХК-ийн Ерөнхий
инженер |
| 5. Мягмардоржийн Уранчимэг | “Бет-Андууд” ХХК-ийн Талбайн
мастер |
| 6. Цэгмидийн Саранцэцэг | БОЭТ-ийн Халдвартын тасгийн
эрхлэгч |
| 7. Ядамжавын Биндэръяа | Орхон аймгийн Татварын хэлтэсийн
Архив бичиг хэргийн эрхлэгч |
| 8. Лувсандоржийн Энхжаргал | Тэтгэвэрт |

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 82

Эрдэнэт хот

**СИТХ-ын ээлжит бус анхдугаар хуралдаан
зарлан хуралдуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.4, 64 дүгээр зүйлийг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус анхдугаар хуралдааныг 2013 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зарлан хуралдуулж, дараах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

Үүнд:

I.Рашаант, Их залуу, Шанд багийг хуваах тооцоо, хөрөнгө оруулалт, орон тоо, бүтцийн талаарх танилцуулга

II. Сумын хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийг хүлээн зөвшөөрөх тухай мэдээлэл

2.Хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын бэлтгэл ажлыг хангахыг сумын Засаг дарга/И.Баасанжав/-д даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 83

Эрдэнэт хот

Засаг даргын үйл ажиллагаанд
үнэлэлт өгөх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18, 25 дугаар зүйлүүдийг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1.Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 2013 оны 09 сарын байдлаар хийсэн ажлыг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэсүгэй.

2.Засаг даргад даалгах нь:

2.1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх

2.2.Үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, явцын талаар бүтэн жилээр хурлын хуралдаанд мэдээлэх

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 84

Эрдэнэт

**Багийн ИНХ хуралдуулах тов
тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, Захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 260 тоот шийдвэрийг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэнбүст багийн ИНХ-ын дарга, багийн Засаг дарга сонгох ИНХ-ыг хүчингүйд тооцсон тул дахин сонгууль явуулах багийн ИНХ-ын хуралдааны товыг хавсралтаар баталсугай.

2.Бүрэнбүст багийн ИНХ-ыг зохион байгуулах байр бусад бэлтгэл ажлыг ханган хуулийн дагуу зохион байгуулах арга хэмжээ авахыг Сумын Засаг дарга /И.Баасанжав/-г үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Орхон аймгийн Баян-Өндөр сумын ИТХ-ын
Тэргүүлэгчдийн 2013 оны 10 сарын 10-ны
өдрийн 84 -р тогтоолын хавсралт

БҮРЭНБҮСТ БАГИЙН ИНХ-ЫН ТОВ

№	Он, сар, өдөр	Цаг	Байр	Хариуцах ажилтан
1	2013.10.27	10.00	Орхон цогцолбор сургууль	М.Эрдэнчимэг /ЗДТГ-ын дарга/ Б.Жаргалсайхан /Баг хариуцсан ажилтан/ Д.Сайнилэг /ЭМБСАХ ажилтан/

оОо



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 85

Эрдэнэт

**Сумын “Хүндэт тэмдэг”-ээр
шагнах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Баян-Өндөр сумын “Хүндэт тэмдэг”-ээр тэргүүний хүмүүсийг шагнах журмыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан дараах хүмүүсийг Баян-Өндөр сумын “Хүндэт тэмдэг”-ээр шагнасугай. Үүнд:

1. Цэгмидийн Ваанчиг – “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ЧХХ-ийн засварчин
 2. Лувсанжанцангийн Сайндэлгэр - “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ЧХХ-ийн хэмжил зүйн албанд Дулаан техник, цулын хэмжлийн лабораторийн мастер
 3. Раднаагийн Санжмятав – Өндөр настан
 4. Нэргэдэгийн Тонир – Өндөр настан
 5. Цэрэндэндэвийн Жүгдэрнамжил – Өндөр настан
2. “Хүндэт тэмдэг”-ээр шагнагдсан нэр бүхий хүмүүст дагалдах мөнгөн шагнал 30 000 /Гучин мянган/ төгрөгийг олгохыг байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт даалгасугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 86

Эрдэнэт

**Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт сумын Засаг даргын саналыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1.Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс 3.Эрдэнээ, В.Хараа, Г.Пүрэвдээ нарыг чөлөөлж, М.Эрдэнэчимэг, Д.Нарантуяа, И.Жаргалсайхан нарыг томилсугай.

2.Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийг хуулийн дагуу удирдлагаар хангаж ажиллахыг Сумын ЗДТГ-ын дарга /М.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 87

Эрдэнэт

**Рашаант, Баянбулаг багийн Амьжиргааг
дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь заалт Рашаант, Баянбулаг багийн ИНХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Рашаант багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Л.Батцэцэг, М.Гантулга, Ө.Мөнхжаргал нарыг чөлөөлж, Ц.Мөнх-Эрдэнэ, П.Сүнжидмаа, Б.Түмэннаст, Л.Хөвсгөл, Д.Долгормаа, Б.Наранцэцэг, М.Даваажав нарыг томилсугай.

2. Баянбулаг багийн Амьжиргааг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнээс Я.Бадмаа, Ж.Сайннямбуу, н.Оюунчимэг, С.Өнөржаргал нарыг чөлөөлж, Х.Төгсбаяр, Г.Ганхаш, Н.Мөнхзул, С.Алтанцэцэг, Д.Батжаргал, Б.Эрдэнэчимэг, С.Оюундэлгэр нарыг томилсугай.

3. Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийг хуулийн дагуу удирдлагаар хангаж ажиллахыг Сумын ЗДТГ-ын дарга /М.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН



**ОРХОН АЙМАГ БАЯН-ӨНДӨР СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2013 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 88

Эрдэнэт

Иргэний танхим байгуулах,
ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Иргэний танхим байгуулах санаачлагыг дэмжин хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1.Сумын хурлын дэргэдэх Иргэний танхимыг 2013 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс байгуулсугай.

2.Сумын Иргэний танхимын ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

3.Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, Иргэний танхимын байнгын, хэвийн ажиллагааг хангаж ажиллахыг Хурлын Нарийн бичгийн дарга /З.Эрдэнээ/, Иргэний танхимын ажилтан /Д.Отгонжаргал/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЖАРГАЛСАЙХАН

Баян-Өндөр сумын ИТХ—ын
Тэргүүлэгчдийн 2013 оны 10 сарын 10 -ны
өдрийн 88 дугаар тогтоолын 1-р хавсралт

БАЯН-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН ДЭРГЭДЭХ ИРГЭНИЙ ТАНХИМЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

Баян-Өндөр сумын ИТХ-ын бодлого шийдвэрт, иргэдийн байр суурь, үзэл бодлыг тусгах, иргэдийн санал санаачлагыг шийдвэр гаргагчид сонсох, олон нийтийн тулгамдсан асуудлыг иргэдийн оролцоотой нээлттэй хэлэлцэх зорилгоор сумын ИТХ-ын дэргэд байгуулагдсан Иргэний танхимын /цаашид Иргэний танхим гэх/ үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. Зорилго, үйл ажиллагааны зарчим

2.1.“Иргэний Танхим”-ын зорилго нь: Төсөл, дүрэм журам, тогтоол, захирамж, шийдвэрүүдийн төсөлд иргэд, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас гаргасан санал, шүүмжлэл, нэмэлт өөрчлөлтийн санаа, мэдээлэл хүлээн авах замаар сумын ИТХ-ын түвшинд гаргах шийдвэрийн үндэслэлийг сайжруулах, шийдвэр гаргахад олон нийтийг оролцуулах явдал юм.

2.2.Иргэний Танхимын бүх үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байна.

2.3.Иргэний Танхимд болох аливаа хэлэлцүүлэг нь тодорхой шийдвэр, баримт бичгийн төслийг үндэслэн, шийдвэр гаргахын өмнөх шатанд иргэдийн оролцоотойгоор нээлттэй явагдана.

2.4.Сумын хэмжээнд тулгамдсан асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг явуулж болно. Хэлэлцүүлгийг энэхүү журмыг баримтлан зохион байгуулна.

ГУРАВ. Үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалт

3.1.Иргэний танхимын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нээлттэй хэлэлцүүлэг байна. Нээлттэй хэлэлцүүлэг нь оролцогч тал, асуудал оруулагч тал болон зохион байгуулагчаас тус тус бүрдэнэ.

3.1.1.Нээлттэй хэлэлцүүлэгт оролцогч нь тус аймгийн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл байна. Мөн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй гадаадын болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийг хэлэлцүүлэг даргалагчийн урилгаар оролцуулж болно.

3.1.2.Нээлттэй хэлэлцүүлэгт асуудал оруулагч нь Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, хурлын хороод, ИТХ-ын дарга, ажлын алба, Сумын Засаг дарга, тэдгээрээс байгууллагдсан ажлын хэсгүүд байна.

3.1.3.Иргэний Танхимын үйл ажиллагааг зохион байгуулагч нь Иргэний танхимын ажилтан байна. Ажлын хэсэг буюу Иргэний танхимын ажилтан нь:

- Нээлттэй хэлэлцүүлгийг олон нийтэд зарлах, иргэдээс санал мэдээлэл хүлээн авах,

- Хэлэлцүүлгийг зохион байгуулах, хэвлэлээр мэдээлж сурталчилах,

- Мэдээллийг цуглуулж эмхэтгэх, саналыг ангилж бэлтгэх, асуудал оруулагч талын тайлан мэдээтэй танилцаж зөвлөмж өгөх ажлыг хариуцна.

3.2.“Иргэний танхим”-ын үйл ажиллагааг Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын алба нэгдсэн удирдлагаар хангана.

3.3.Иргэний танхимд нээлттэй хэлэлцүүлгийн бус цагаар иргэдийн оролцоог хангах, мэдээлэл хүргэх зорилгоор иргэдийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулна.

3.3.1.Баг, хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарыг сурган тэд нараар дамжуулан шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийг идэвхижүүлэх арга зүйн сургалт зохион байгуулна.

3.3.2.Төр, ТББ болон бусад байгууллагын захиалгаар иргэдийн дунд явуулах хууль эрх зүй, эрүүл мэнд, сэтгэлзүйн зэрэг иргэдийн хэрэгцээ шаардлагад суурилсан сургалтыг хамтран зохион байгуулна.

3.3.3.Иргэний танхимын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх үүднээс хөдөлгөөнт Иргэний танхимыг алслагдсан багийн иргэдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулах, мэдээлэл өгөх, санал бодлыг нь сонсох зорилгоор ажиллуулна.

3.3.4.Сумын ИТХ-ын Төлөөлөгчид үйл ажиллагаагаа иргэдэд танилцуулах, тэдний санал бодлыг сонсох зорилгоор иргэдтэй уулзалт хийнэ.

Үүнд:

- Сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн иргэдтэй хийх уулзалтын төлөвлөгөөг хурлын ажлын алба боловсруулж иргэд болон Төлөөлөгчдөд мэдээллэнэ.

- Сумын ИТХ-ын Төлөөлөгчид үйл ажиллагааны тайлангаа Иргэний танхимд хүргүүлж, иргэдэд нээлттэй танилцуулна.

3.4.Иргэний танхимын төсөв, бүтэц, орон тоог ИТХ-ын Тэргүүлэгчид батална.

3.5.Сумын ИТХ-ын Ажлын алба нь хэлэлцүүлэг эхлэхээс 14 хоногийн өмнө хэлэлцүүлэх асуудалтай танилцан холбогдох чиглэл, удирдамжаар хангана.

ДӨРӨВ. Хэлэлцэх төсөл сэдвийг олон нийтэд зарлах, иргэдийн саналыг хүлээн авах

4.1.Нээлттэй хэлэлцүүлгийн төслийн анхны эх, түүний товч агуулга, төслийн үндэслэлийн танилцуулгыг ажлын 14-өөс доошгүй хоногийн өмнө Иргэний танхимын ажилтан хүлээн авсан байна.

4.2.Иргэний танхимд хэлэлцэх төслийн анхны эх, хэлэлцүүлэг болох он, сар өдөр, байр, цаг, үргэлжлэх хугацаа, иргэдийн санал хүлээж авах хаяг, электрон шуудан, лавлагаа авах, хэлэлцүүлэгт биечлэн оролцохоор бүртгүүлэх утасны дугаар, хаягийг дурдсан албан ёсны зарыг төслийн танилцуулгыг авсан өдрөөс эхлэн хэвлэл мэдээлэл, интернэтээр зарлана.

4.3.Хэлэлцүүлэгт оролцогч нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр хэлэлцүүлэг зарлагдмагц дараахь хэлбэрээр санал шүүмжлэл, байр сууриа илэрхийлж болно. Үүнд:

4.3.1.“Орхон аймаг, Баян-Өндөр сумын ИТХ-ын дэргэдэх Иргэний Танхимд” гэж хаягласан захидлаар.

